

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ӨМНӨХ МАКРО ЭДИЙН
ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ТӨЛӨВ
БАЙДЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2021 он**

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

АГУУЛГА

БҮЛЭГ НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС 2017-2021 ОНЫ ХООРОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН .. 5

1.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН	5
1.1.1. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлтийн байдал	6
1.1.2. Мөнгөний нийлүүлэлт, инфляц.....	7
1.1.3. Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, валютын ханш	9
1.1.4. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурал	11
1.1.5. Барилга, хот байгуулалт	13
1.1.6. Зам, тээврийн салбар	18
1.1.7. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар.....	19
1.1.8. Эрчим хүчний салбар.....	21
1.1.9. Хөдөө аж ахуйн салбар.....	23
1.2. САНХҮҮГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН	26
1.2.1. Банкны салбар	26
1.2.2. Хөрөнгийн зах зээл	30
1.2.3. Даатгалын зах зээл.....	35
1.2.4. Бичил санхүү	39
1.2.5. Монгол Улсын Хөгжлийн банк	44
1.2.6. Банкин дахь мөнгөн хадгаламжийн тогтолцоо	45
1.3. ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН	47
1.3.1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл.....	47
1.3.2 Төсвийн зарлагад баримталсан бодлого, хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр, арга хэмжээ, бодлогын өөрчлөлт болон салбаруудад авч хэрэгжүүлсэн төсвийн бодлогын арга хэмжээ	49
1.3.3 Татвар, орлогын чиглэлээр баримталсан бодлого, томоохон бодлогын өөрчлөлт, түүний үр дүнгийн тухай.....	55
1.3.4 Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, томоохон бодлогын өөрчлөлт, түүний үр дүнгийн тухай	58
1.4 Төсвийн тусгай шаардлага.....	64
1.4.1 Төсвийн орлогын тусгай шаардлага.....	64
1.4.2 Төсвийн тэнцлийн тусгай шаардлага	65
1.4.3 Зарлагын өсөлтийн тусгай шаардлага	65

БҮЛЭГ ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ, НӨХЦӨЛ, ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨӨГҮЙ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ӨР БА ХҮҮГИЙН ТӨЛБӨРИЙН ДҮН

67

2.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ЗОРИЛТ.....	67
2.1.1. Засгийн газрын өрийн өнөөгийн байдал.....	69
2.1.2. Засгийн газрын дотоод үнэт цаас	70
2.1.3. Өрийн бичиг.....	71
2.1.4. Гадаад үнэт цаас /бонд/.....	71
2.1.5. Гадаад зээл.....	72
2.1.6. Засгийн газрын өрийн баталгаа.....	73
5.1.6. "Барих-шилжүүлэх" төрлийн концесс.....	74
2.2. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР	76
БҮЛЭГ ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ҮЛДЭГДЛИЙН НИЙТ ДҮН, ЭНЭ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ДАРААГИЙН ЖИЛИЙН ХУГАЦААН ДАХЬ ТУХАЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ҮНЭЛГЭЭ	
3.1. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНД ШИЛЖҮҮЛСЭН ЭРДЭС, БАЯЛГИЙН ОРЛОГО, САНГИЙН ЗАРЛАГА.....	78
3.2. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ХУРИМТЛАЛЫН ТАЛААРХ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ	79
БҮЛЭГ ДӨРӨВ. СОНГУУЛИЙН ЖИЛД ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ ДАРААГИЙН ЖИЛҮҮДИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ҮЗҮҮЛЭЛТ .	
4.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНД ТӨСВӨӨС ГАРГАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	80
БҮЛЭГ ТАВ. ИРЭХ ДӨРВӨН ЖИЛИЙН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ.....	
5.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ.....	81
5.2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ	82
5.3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨСӨӨЛӨЛ.....	82
ЗУРГАА. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ НЬ УЛСЫН ИХ ХУРЛААР БАТЛАГДСАН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, ЭСХҮЛ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙГАА ТАЛААРХ ТАЙЛБАР	
6.1. ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ НЬ ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БУЙ ТАЛААР	86
6.2. ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛТЭЙ НИЙЦЭЖ БУЙ ТАЛААР	87

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн Хөгжлийн банк
ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
ЕХОБ	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн Банк
МУТС	Мөнгө угаах, Терроризмыг санхүүжүүлэх
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУВС	Олон Улсын Валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨБҮХХ	Өмчлөх бус үл хөдлөх хөрөнгө
ТЗК	Тусгай зориулалтын компани
ТТС	Төсвийн тогтворжуулалтын сан
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
УИХ	Улсын Их Хурал
ҮЦК	Үнэт цаасны компани
ХААХОУС	Хөдөө Аж Ахуйг Хөгжүүлэх Олон Улсын Сан
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо

БҮЛЭГ НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС 2017-2021 ОНЫ ХООРОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

1.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлж, тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх¹, эдийн засгийн гадаад, дотоод орчны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, төсвийн нэгдмэл байдлыг хангаж, сахилга батыг сайжруулах хүрээнд 2017-2021 онд дараах бодлогыг барьж ажиллаа. Үүнд:

- Монгол Улсын төсвийн нэгдмэл байдлыг хангаж, төсвийн сахилга батыг сайжруулж, төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах, Монголбанк, Монгол Улсын хөгжлийн банкаар дамжуулан төсвийн шинж чанартай зарлагыг санхүүжүүлж байсныг зогсоох;
- Засгийн газрын өрийн хэмжээг бууруулж, арилжааны нөхцөлтэй гадаад, дотоод зээл авахаас татгалзах, нэн шаардлагатай хөгжлийн бүтээн байгуулалтыг хөгжлийн түншүүдээс авах хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх;
- Иргэдийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын зардлыг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг хамгаалж, эдийн засгийн нийт эрэлтийг зохистойгоор дэмжих;
- Төсвийн алдагдлыг өндөр хүүтэй, арилжааны зээлээр санхүүжүүлж байсныг зогсоож, Засгийн газрын мөнгөн хөрөнгө, өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх замаар санхүүжилтийн хэрэгцээг хангах;
- Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих татварын орчныг бүрдүүлж, гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулж, нийгмийн шинж чанартай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэг зэрэг нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны алдагдлыг бууруулж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэн, эдийн засгийн эрсдэл даах чадварыг сайжруулах;
- Эрчим хүч, зам тээвэр, хүнс, хөдөө аж ахуй, нийтийн аж ахуйн салбарт шаардлагатай дэд бүтцийг улсын төсөв, гадаадын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барьж байгуулах;
- Банк, санхүүгийн салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн, эрсдэл даах чадварыг сайжруулах замаар зээлийн хүүг бууруулах.

Засгийн газраас хэрэгжүүлсэн эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлого, арга хэмжээний үр дүнд Монгол Улсын эдийн засаг 2017 онд 5.3 хувь, 2018 онд 7.2 хувь, 2019 онд 5.2 хувь болж нэмэгдсэн байна. Харин дэлхий нийтээр цар тахалд нэрвэгдсэн 2020 онд эдийн засаг 5.3 хувийн уналттай гарлаа. Эдийн засгийн бодит өсөлт 2017 оноос хойш өсөхөд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн дээр дурьдсан бодлогын арга хэмжээ, Олон Улсын Валютын Сан, хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” бодит нөлөө үзүүлсэн.


¹ Эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2 хувь болж буурсан.

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2016 онд 1.3 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 4.5 тэрбум ам.доллар болж 3.5 дахин нэмэгдэж, гадаад валютын ханшийн огцом хэлбэлзэл арилсан байна. Макро эдийн засаг, төсөв, санхүүгийн нөхцөл байдал сайжирсантай холбоотойгоор Монгол Улсын зээлжих зэрэглэл 2016 онд В- (S&P), В- (Fitch), Сaa1 (Moody's) байснаас 2019 онд В (S&P), В (Fitch), В3 (Moody's) болж нэмэгдсэн бөгөөд зээлжих зэрэглэлийн үнэлгээ өгдөг байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн цаашдын төлөвийг тогтвортой гэж үнэлсэн байна.

1.1.1. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлтийн байдал

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 37.0 их наяд төгрөгт хүрч, 2017 онтой харьцуулахад 32.6 хувиар өссөн байна. Эдийн засгийн бодит өсөлт 2017-2020 онд дунджаар 3.1 хувь байлаа. Уг өсөлтөд боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа, санхүү болон даатгалын салбарын үйл ажиллагааны өсөлт голлон нөлөөлсөн байна. 2020 он бол дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл 1929 оны их хямралаас хойш хамгийн хүчтэй унасан жил боллоо. Цар тахлын уршгаар улс орнуудын эдийн засаг уналттай, төсвийн алдагдал нь 10-20 хувьд хүрч өссөн жил байлаа. Монгол Улсын эдийн засаг 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5.3 хувийн агшилттай гарсан бөгөөд үүнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөлөөгөөр уул уурхай, тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарууд ихээхэн уналттай гарсан нь нөлөөлжээ. 2020 онд аж үйлдвэрийн салбар 6.2 хувь, үйлчилгээний салбар 7.1 хувийн агшилттай байгаа ч ХАА-н салбар 6.2 хувийн өсөлттэй байна.

Зураг 1. Эдийн засгийн бодит өсөлт, хувиар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
*Урьдчилсан гүйцэтгэл

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2017-2020 оны хооронд 1.6 дахин өсөж 3.9 их наяд төгрөг болсон нь мах болон сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.1 дахин өссөн, кокс шахмал түлшний үйлдвэрлэл 4.8 дахин өссөнтэй холбоотой байна. Худалдааны салбарын нийт борлуулалт мөн хугацаанд 1.7 дахин өсөж 22.0 их наяд төгрөг болжээ.

Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн хувьд 2017 оныг 2020 онтой харьцуулбал ДНБ-д эзлэх боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын хувь, хэмжээ 1.4-1.6 хувиар нэмэгдсэн бол уул уурхай, олборлох салбарын эзлэх хувь, хэмжээ 2.3 хувиар буурч, үүнийг дагаад тээвэр ба худалдааны салбарууд 1-1.4 хувиар буурсан байна.

Зураг 2. ДНБ-ий бүтэц, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
* - урьдчилсан гүйцэтгэл


Дэлхий нийтэд КОВИД-19 шинэ төрлийн коронавирусийн тархалт цар тахлын хэмжээнд хүрч дэгдсэн нь худалдааны гол түнш орон БНХАУ төдийгүй дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2020 онд эрс саарууллаа. Энэ нь манай улсын гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт буурах, иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн хэвийн үйл ажиллагаа алдагдан, худалдан авалт, нийт эрэлт багасаж эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна. Тиймээс Засгийн газраас шинэ төрлийн коронавирусийн тархалт, цар тахлын эдийн засаг, иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээг тодорхойлон Улсын Их Хурлаар батлуулан ажиллаж байна. Тухайлбал, вирусийн нөлөөнд өртөн үйл ажиллагаа, орлого нь хүндрээд байгаа иргэд болон ААН-ийг орлогын албан татвар болон НДШ-ээс чөлөөлөх, хойшлуулах, ажлын байрыг хадгалахад дэмжлэг үзүүлэх, малчдын орлогыг дэмжих цогц арга хэмжээ авч ажиллаж байна.

1.1.2. Мөнгөний нийлүүлэлт, инфляц

Мөнгөний нийлүүлэлт. Мөнгөний нийлүүлэлт 2017 онд 15.9 их наяд төгрөг байсан бол 2020 онд 24.2 их наяд төгрөгт хүрч 52.7 хувиар өссөн байна. Үүнд, төгрөгийн харилцах 55.5 хувиар, төгрөгийн хадгаламж 55.4, валютын хадгаламж 83.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн. Харин гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө энэ хугацаанд харьцангуй бага буюу 9.4 хувиар өссөн. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх хэсгийг хадгаламжийн өсөлт бүрдүүлсэн ба эдийн засаг 2017-2019 онуудад сэргэж урт хугацааны тогтвортой өсөлт рүү чиглэсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд дэмжлэг болсон. Харин 2020 оны эхний хагаст КОВИД-19 цар тахлын улмаас мөнгөний нийлүүлэлтийн хурд саарсан хэдий ч 2020 оны

сүүлийн хагаст эргэн сэргэж өсөх хандлагатай байсан. M2 мөнгөний өсөлтийг санхүүгийн салбарын гадаад цэвэр активын өсөлт голлон тодорхойлж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн бүтцэд эерэг өөрчлөлт болж, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханшид үзүүлэх сөрөг нөлөө бага байхад нөлөөлж байна.

Зураг 3. Мөнгөний нийлүүлэлт, бүтцээр, улирлаар /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
*Урьдчилсан гүйцэтгэл

Инфляц. Эдийн засгийн өсөлт сэргэж, нийт эрэлт өссөнтэй холбоотойгоор инфляцын түвшин 2017 онд 6.4 хувь байсан. Инфляцын түвшинг тогтвортой нам түвшинд барих, төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог хангаж ажилласны үр дүнд инфляцын түвшин 2017-2020 онд мөнгөний бодлогын зорилтот түвшний орчим, тогтвортой бага байлаа. Инфляц 2020 онд цар тахлын улмаас эдийн засаг агшиж, бизнесийн үйл ажиллагаа саарсан тул 2.3 хувь болов.

Зураг 4. Инфляц, улирлаар, өмнөх оны мөн үеийн өөрчлөлт, 2017-2020 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


1.1.3. Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, валютын ханш

Гадаад худалдаа. Гадаад худалдааны нийт эргэлт 2017 онд 10.5 тэрбум ам.доллар байсан бол 2020 оны эцэст 12.9 тэрбум ам.доллар болж 22.8 хувиар өссөн бөгөөд худалдааны тэнцэл 2017 онд 1.9 тэрбум ам.долларын ашигтай байсан бол 2020 онд мөн 2.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспортын хэмжээ 2017 онд 6.2 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 7.6 тэрбум ам.доллар болж 22.6 хувиар, импортын хэмжээ 2017 онд 4.3 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 5.3 тэрбум ам.доллар болж 23.2 хувиар тус тус өссөн байна.

2020 онд алтны экспортын биет хэмжээ түүхэн дээд хэмжээнд хүрчээ. КОВИД-19 цар тахлын тархалттай холбоотойгоор хөрөнгө оруулагчдын дунд тодорхой бус байдал нэмэгдсэнээр дэлхийн зах зээл дэх алтны үнэ түүхэн дээд хэмжээнд хүрсэн. Монголбанк алтны нөөцөөс 30.5 тонн алтыг экспортод гаргасан байна. Төмрийн хүдэр экспортлогч улсуудад КОВИД-19 цар тахлын холбоотойгоор уурхайнууд үйл ажиллагаагаа түр хааснаар нийлүүлэлт буурч, төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн үнэ өндөр байна. Манай улсын хувьд төмрийн хүдрийн олборлолт, экспортын тээвэрлэлтэд саад учраагүй тул өнөө үед экспортын биет хэмжээ өссөөр байна.

Зураг 5. Гадаад худалдаа /тэрбум ам.доллар/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төлбөрийн тэнцэл. Төлбөрийн тэнцэл 2016 оны эцэст 18.2 сая ам.долларын алдагдалтай гарч байсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 786.9 сая ам.долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцлийн дансуудаар авч үзвэл урсгал ба хөрөнгийн данс 327.2 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 1269.3 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 2016 онд 608.9 сая ам.доллар байсан нь 2020 онд ийнхүү буурахад бараа, үйлчилгээний худалдааны алдагдал буурсан нь голлон нөлөөлсөн байна. КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор гадаад худалдааны эргэлт буурч, түүнтэй уялдсан үйлчилгээний салбар зогсонги байдалд орсноор

урсгал ба хөрөнгийн данс агшсан дүр зурагтай байна. Мөн 2020 онд Худалдаа Хөгжлийн Банк өөрийн гаргасан гадаад үнэт цаасны үндсэн төлбөрийг төлж барагдуулснаар санхүүгийн дансны ашиг буурсан үзүүлэлттэй гарчээ.

Зураг 6. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/




Эх сурвалж: Монголбанк

Валютын ханш. 2017 оны эцэст гадаад валютын улсын нийт албан нөөц 3 тэрбум ам.долларт хүрч мөн онд төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2.5 хувиар чангарсан үзүүлэлттэй гарсан. Засгийн газар, Төв банкнаас гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд алт олборлолтыг дэмжиж, алтны худалдан авалтыг нэмэгдүүлсний үр дүнд гадаад валютын албан нөөц 2020 оны эцэст 4.5 тэрбум ам.доллар болж түүхэн дээд хэмжээнд хүрлээ.

АНУ-ын Холбооны нөөцийн банкны бодлого, АНУ, БНХАУ-ын хоорондох худалдааны маргаан зэрэг гадаад хүчин зүйлстэй холбоотойгоор олон улсын зах зээлд ам.долларын ханш чангарч байсан нь төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2017-2020 оны хооронд жилд дунджаар 3.6 хувиар сулрах (энэ тооцоонд 2017, 2018, 2019, 2020 онууд орсон, харин 2018, 2019, 2020 оны хувьд тооцвол жилд дунджаар 5.8 хувь байгаа болно) үндсэн хүчин зүйл болсон. Гэвч, Монгол Улстай адил эрдэс баялаг экспортлогч бусад орнууд болох Аргентин, Бразил, Чили, Өмнөд Африк зэрэг улсуудын валют ам.долларын эсрэг 28-30 хувиар суларч байсантай харьцуулахад ам.долларын эсрэг төгрөгийн ханшийн сулралт харьцангуй бага байна.

Зураг 7. Гадаад валютын албан нөөц ба валютын ханш



Эх сурвалж: Монголбанк

1.1.4. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурал

Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл. Ажилгүйдлийн түвшин 2017 оны 4 дүгээр улиралд онд 7.3 хувьтай байсан бол 2020 оны мөн үед 7.6 хувь болжээ. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажил хайгч иргэний тоо 2017 оны эхэнд 47.3 мянган байснаас 34.3 мянга нь ажилгүй иргэд байсан бол 2020 оны эцэст ажил хайгч иргэний тоо 30.0 мянга, үүнээс бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 18.1 мянга болж тус тус буурсан байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2020 оны эцсийн байдлаар 47.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн


	2017-IV	2018-IV	2019-IV	2020-IV
15-аас дээш насны хүн ам	2,189.9	2,173.0	2,132.1	2,134.7
Ажиллах хүч	1,367.3	1,345.3	1,293.6	1,216.6
Ажиллагчид, 15-аас дээш насны	1,266.9	1,256.4	1,188.4	1,124.6
Ажилгүй иргэд	100.3	88.9	105.1	92.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	822.7	827.8	838.5	918.1
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар	62.4	61.9	60.7	57.0
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар	57.9	57.8	55.7	52.7
Ажилгүйдлийн түвшин, хувиар	7.3	6.6	8.1	7.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын Засгийн газар 2016 онд хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-үүдийг батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдад сар бүр 200 мянган төгрөгийн мөнгөн тэтгэлэг олгох арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь мэргэжилтэй ажиллагсдыг бэлтгэхэд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Цалин хөлс. Нэг өрхийн сарын дундаж орлого 2016 оны 4 дүгээр улиралд 914.9 мянган төгрөг байсан бол 2020 оны мөн үед 1424.6 мянган төгрөг болж 55.7 хувиар өссөн байна. Тус өсөлтийг бүтцээр нь задлан харвал цалин хөлсний орлого 28.3 нэгж хувийг, тэтгэвэр тэтгэмжийн орлого 14.9 нэгж хувийг, МАА-н үйлдвэрлэлийн орлого 4.3 нэгж хувийн өсөлтийг бий болгон нөлөөлсөн байна.

Зураг 8. Нэг өрхийн сарын дундаж орлого, бүтцээр 2017-2020, сая төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, туршилтын хугацаагаар ажиллах, дагалдан ажиллуулах хугацаа, цагаар ажиллах зохицуулалтыг хуульд нэмж, цагаар ажилласан ажилтны цагаар болон хийснээр нь олгох цалингийн хэмжээ нь ижил ажлын байранд бүрэн цагаар ажилладаг ажилтнытай адил байх, ажилтан хөдөлмөрийн нормоо биелүүлээгүй ч гүйцэтгэсэн ажилдаа тохирсон цалин хөлс авахаар хуульчиллаа. Засгийн газраас салбарын болон аж ахуй нэгжийн түвшинд ур чадвар, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний зохистой тогтолцоо, шударга хуваарилалтыг тогтоох механизмыг бүрдүүлэх, ажиллагчдын ур чадвар, бүтээмжийг урамшуулах бодлого баримтлан төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн.

Ядуурал. Ядуурлын түвшин 2016-2018 оны хооронд 29.6 хувиас 28.4 хувь болж 1.2 нэгж хувиар буурлаа. Ядуурлын шугам буюу хүн амын амьжиргааны доод түвшин 2016 онд 146.1 мянган төгрөг байсан бол 2018 онд 166.6 мянган төгрөг болсон байна.

Ядуу хүн амын дундаж хэрэглээ ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг хэмждэг ядуурлын гүнзгийрэлтийн хувьд 2016 онд 7.7 хувь байсан бол 2018 онд 7.2 хувь болж 0.5 нэгжээр буурсан. Түүнчлэн ядуу хүн амын орлого хуваарилалт ядуурлын хамгийн доод түвшинд ямар хэмжээтэй байгааг харуулдаг ядуурлын мэдрэмжийн үзүүлэлт мөн 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Ядуурлын үндсэн үзүүлэлт

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	2016	2018	2016	2018	2016	2018
Ядуурлын хамралтын хүрээ	29.6	28.4	27.1	27.2	34.9	30.8

Ядуурлын гүнзгийрэлт	7.7	7.2	7.2	7.2	8.8	7.2
Ядуурлын мэдрэмж	2.9	2.7	2.8	2.8	3.2	2.4

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Засгийн газар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр УИХ-аас баталсан “Нийгмийн халамжийн тухай”, “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030/”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд харах үйлчилгээний тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” болон холбогдох бусад хуулиудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1.5. Барилга, хот байгуулалт

Барилга, хот байгуулалтын салбарын хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчныг хангасан хот суурин газрыг төлөвлөх, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, инженерийн дэд бүтцийг сайжруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллаа.

2020 онд барилга угсралт, их засварын ажил нийт дүнгээр 4.7 их наяд төгрөг болсон байна. 2017 онд 3.78 их наяд төгрөг байсантай харьцуулахад 0.92 их наяд төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн байна. Тус өсөлтөд орон сууцны бус барилгын хэмжээ 0.31 их наяд төгрөг, инженерийн барилга байгууламж 0.51 их наяд төгрөгөөр өсөж голлох нөлөө үзүүлсэн байна.

Зураг 9. Барилга угсралт, их засварын ажил, барилгын төрлөөр, улирлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хот байгуулалт. Улс, орон нутгийн хөгжилд чухал ач холбогдол бүхий хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Баруун бүсийн тулгуур төв Ховд, Улиастай, Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан, Өндөрхаан, Төвийн бүсийн тулгуур

төв Дархан, Зуунмод, түүнчлэн Архангай аймгийн Цэцэрлэг, Өвөрхангай аймгийн Арвайхээр хот, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих Багануур хот”, “Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг даган бий болох Шинэ Зуунмод хот”-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг тус тус боловсруулж батлуулаад байна.

Энэ хүрээнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, Булган аймгийн Булган, Замын-Үүд чөлөөт бүс, “Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумын төв”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, “Алтанбулаг, Бичигт, Замын-үүдийн хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, “Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг даган бий болох Шинэ Зуунмод хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичгийг тус тус боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.


Мөн Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл, хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй агаар, ус, хөрсний бохирдол, сөрөг нөлөөг бууруулах, олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орон нутгийн зэрэглэлтэй “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай шийдвэрийг Улсын Их Хурлын 2020 оны 55 дугаар тогтоолоор батлуулж, “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцийг боловсруулаад байна.

Орон сууц. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын 2016 оны 38, 298, 169 дүгээр тогтоолуудаар 1512 айлын орон сууцыг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д, 2019 оны 223 дугаар тогтоолоор 1542 айлын орон сууцыг аймаг, нийслэлийн өмчийн түрээсийн орон сууцны санд, нийт 3052 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлээд байна.

Мөн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан ипотекийн зээлийн нөхцөлийг үе шаттай хөнгөвчлөх ажлын хүрээнд Монголбанк, арилжааны банкууд, “МИК ОССК” ХХК-иудтай хамтран ипотекийн зээлийг 6 хувь болгож 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс шинээр зээл авах иргэдэд олгож эхэлсэн. Ингэснээр иргэдийн сарын төлбөрийн хэмжээ 20 орчим хувиар буурч байгаа буюу өрхийн нотлох орлогын хэмжээг мөн хувиар бууруулж, иргэдийн ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлж байна. 2020.10.01-ний өдрөөс 2021 оны 2 дугаар сарын байдлаар нийт 2168 зээлдэгчид 149.5 тэрбум төгрөгийн 6 хувийн хүүтэй зээл олгоод байна. Ийнхүү иргэдийн орон сууц худалдан авах нөхцөлийг сайжруулж байгаа нь нөгөө талдаа барилгын салбарын аж ахуй нэгжүүдийн борлуулалтыг дэмжих бодлоготой уялдаж байна.

Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Засгийн газраас “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”, мөн иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах бодлогын хүрээнд “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

Зураг 10. Орон сууцны зээлийн олголтын хэмжээ, эх үүсвэрээр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Орон сууцны зээлд 2017 оны эцэст 93,147 иргэн хамрагдаж байсан бол 2020 оны эцэст 100,496 иргэн болж тус хугацаанд 2.3 их наяд төгрөгийн зээл олгосон байна. Үүний 46.2 хувийг буюу 1.2 их наяд төгрөгийн зээлийг ипотекийн зээлийн хөтөлбөрийн дагуу 8% болон 5%-ийн хүүтэй олгосон байна.

Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор “150 мянган айл–орон сууц” үндэсний хөтөлбөр батлагдаж, тус хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт "Ногоон нуур - 1008 айлын орон сууц" төсөл, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт "Солонго -1", "Солонго - 2" 5002 айлын орон сууцны төсөл, Сонгинохайрхан нутаг дэвсгэрт "Баянголын ам" 2000 айлын орон сууцны төслүүдийг хэрэгжүүлж байна.

Инженерийн дэд бүтэц. Монгол Улсын Засгийн газар 2016-2020 онд нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, эдийн засгийг төрөлжүүлэх, бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг санхүүжүүлэх, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод болгох, цахим орчныг бүрдүүлэх, эдийн засгийг дэмжих, тогтворжуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагуудтай нийт 4.7 тэрбум ам.доллар, 26.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хэлэлцээрүүдийг байгууллаа. Эдгээр хэлэлцээрүүдийн хүрээнд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах чиглэлээр дараах төслүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. БНХАУ-ын Экспорт-Импорт банкттай байгуулсан 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл;

2. АНУ-ын Мянганы сорилтын сангийн 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн компакт гэрээгээр Улаанбаатар хотын усан хангамжийг сайжруулах, хаягдал усыг дахин боловсруулж, үйлдвэрийн зориулалтаар ашиглах төсөл;
3. БНХАУ-ын Экспорт-Импорт банктай байгуулсан 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл, Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны авто зам барих төсөл, Туул гол дээгүүрх Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр шинээр барих төсөл, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км автозам барих төсөл, Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км зам барих төсөл, Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих төсөл, Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто зам барих төсөл зэрэг томоохон зам, тээврийн дэд бүтцийн төсөл;
4. Европын сэргээн босголт, хөгжлийн банктай байгуулсан 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд Улаанбаатар дулааны сүлжээ төсөл, Улаанбаатар-Дархан чиглэлд нэмэлт хоёр эгнээ авто зам шинээр барих төсөл;
5. Азийн хөгжлийн банктай байгуулсан 1.26 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн замын өргөтгөл шинэчлэл төсөл, Улаанбаатар хотод төлбөрийн чадварт нийцсэн 10,000 айлын орон сууц барих төсөл, Баруун болон Алтай-Улиастайн бүсэд нийт 40 мВт-ын хүчин чадал бүхий нар, салхин цахилгаан станц барих, 34 сургууль цэцэрлэг шинээр барих, өргөтгөл, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлэг, орон нутгийн эмнэлгийн өргөтгөл 2, өрхийн эмнэлэг 10, сумдын эмнэлэг 6, түргэн тусламжийн төвийн барилга барих төслүүд;
6. БНСУ-ын Экспорт-Импорт банктай 700 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээр байгуулж, энэ хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор зорилтот бүлэгт чиглэсэн түрээсийн орон сууцны хороолол барих, 10 аймгийн төвд дулааны станц барих төсөл, хууль, эрх зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх төсөл;
7. Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн хүрээнд АХБ-тай байгуулсан 20.0 сая ам.долларын зээлийн хэлэлцээрийн дагуу Булган, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар аймгуудын төвийн цэвэрлэх байгууламжийг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлж байна;
8. АХБ-тай байгуулсан 18.5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах 3244/3245” төсөл;
9. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2016 онд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд 14.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Тайшир-Алтай ус хангамжийн төсөл”;
10. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2016 онд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд 5.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн “Дэд бүтцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл”;
11. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2016 онд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд 7.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн “Дэд бүтцийн хөгжил-Сонгино хайрхан төсөл”.

Газрын харилцаа, геодези, зураг зүй. Монгол Улсын Засгийн газар 2016-2020 онд Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох

замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх зорилтын хүрээнд Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 45 хувь буюу 704 000 км² талбайг 7328 хуудас байр зүйн зургаар зурагжууллаа. Үүний үр дүнд геологи, уул уурхай, хөдөө аж ахуй, зам тээвэр, аялал жуулчлал, онцгой байдал, батлан хамгаалах, хил хамгаалах, дэд бүтцийн төлөвлөлт, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн суурь тоон өгөгдөл гэх мэт нийгэм, эдийн засгийн голлох салбаруудыг суурь мэдээллээр ханган ажиллах боломжтой болсон;

Мөн төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулах зорилтын хүрээнд Геодезийн цэг, тэмдэгтээр үйлчлэх (cors.gazar.gov.mn), ГЕОПОРТАЛ буюу байрлалд суурилсан орон зайн мэдээллийн үйлчилгээний цахим систем (nsdi.gov.mn), Агаар, сансрын зураг, өндрийн тоон загварын тоон мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэх цахим хуудас (raster.gazar.gov.mn), Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем (www.egazar.gov.mn), Хот байгуулалтын кадастрын систем (urban.gov.mn), Геодезийн багаж баталгаажуулалтын цахим систем (bagaj.gazar.gov.mn), Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох цахим систем (license.gazar.gov.mn), Архивын бүртгэлийн систем (Archive Pro) зэрэг системүүдийг Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн “ХУР” систем болон бусад төрийн байгууллагын цахим системээс шаардлагатай мэдээлэл, үйлчилгээг авч холбогдон төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжүүдээс шаардахгүй байх зарчмыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдмэл, баталгаатай байдлыг хангаж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болголоо.

Зураг 11. Газрын удирдлагын нэгдсэн систем



Зураг 12. Суурь орон зайн мэдээлэл



17

1.1.6. Зам, тээврийн салбар

Тээврийн салбарын тухайн жилд зөөвөрлөж буй ачаа 2017-2019 оны хооронд 27.8 хувиар өсөж 69.0 сая тонн болж өссөн бөгөөд тээврийн нийт орлого нь 40.9 хувиар өсөж 2.0 их наяд төгрөг болоод байв. Харин 2020 онд цар тахалтай холбоотойгоор тус үзүүлэлтүүд ихээхэн буурсан ба зөөвөрлөсөн ачаа 60.3 сая тонн, тээврийн нийт орлого 1.5 их наяд төгрөг болжээ.

Хүснэгт 3. Зам тээврийн салбарын үндсэн үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	2017	2018	2019	2020	2020/2017 (хувь)
Нийт тээвэрлэсэн ачаа, мянган тонн	53,983.4	67,802.9	68,997.5	60,458.8	12.0%
Төмөр зам	22,765.1	25,763.3	28,143.0	30,001.2	31.8%
Авто	31,212.9	42,033.8	40,848.8	30,454.9	-2.4%
Агаарын	5.4	5.8	5.8	2.7	-49.3%
Нийт ачаа эргэлт, сая тонн километр	19,167.8	21,969.5	23,564.0	23,861.0	24.5%
Төмөр зам	13,493.3	15,315.3	17,384.1	19,167.6	42.1%
Авто	5,661.3	6,640.6	6,203.8	4,685.3	-17.2%
Агаарын	13.2	13.6	13.4	8.1	-38.6%
Нийт зорчигчдын тоо, сая хүн	216.1	197.0	173.0	126.5	-41.4%
Төмөр замын	2.6	2.6	3.0	2.0	-24.2%
Авто	212.2	193.0	168.4	124.1	-41.5%
Агаарын	1.3	1.4	1.6	0.4	-64.2%
Усан замын	0.0	0.0	0.0	-	-100.0%

Нийт зорчигч эргэлт, сая хүн километр	5,434.	6,598.1	7,157.9	3,416.9	-37.1%
Төмөр зам	973.2	993.7	1,113.4	579.3	-40.5%
Авто тээвэр	2,040.9	2,919.9	2,925.1	2,178.0	6.7%
Агаарын тээвэр	2,420.2	2,684.2	3,119.2	659.6	-72.7%
Усан замын тээвэр	0.4	0.6	0.6	0.4	2.6%
Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг	1,422.2	1,754.4	2,003.5	1,504.9	5.8%
Төмөр замын	530.0	616.0	708.6	775.9	46.4%
Авто	506.4	695.9	796.1	564.4	11.4%
Агаарын	385.5	442.3	498.2	164.1	-57.4%
Усан замын	0.3	0.5	0.4	0.5	66.7%

Эх сурвалж: Зам, тээвэр хөгжлийн яам

Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээг үзүүлэх зорилтын хүрээнд авто зам, авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам, агаарын тээврийн салбарыг хөгжүүлж байна.

Голлох авто замын төслүүдийг дурдвал Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах, түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээний хүрээнд Яармагийн 260 у/м шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах, Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих, Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр барих, Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэл хийх зэрэг төслүүдийг хэрэгжүүлэв.

Зам-Үүдэд тээвэр логистикийн төв байгуулах ажлын хүрээнд төслийн барилга угсралтын ажлыг дуусгаж, улсын комисс 2018 оны 12 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд ажиллаж, 18/432/02 дугаар актаар ашиглалтад хүлээн авсан байна. Төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам, Улаанбаатар төмөр замын шинэчлэлийн төсөл, Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр зам, Богд Хан төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой -Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслүүдийг хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг авч “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр зам, “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн.

1.1.7. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар

Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2017 онд 9.35 их наяд төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 11.7 их наяд төгрөг болж, 2017 онтой харьцуулахад 25.1 хувиар өссөн байна. Уул уурхайн салбар 2020 онд нийт экспортын 92.8 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 4. Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл.

	2017	2018	2019	2020	2020/2017 (хувиар)
Нүүрс (мян.т)	48,145.1	51,401.3	55,799.4	40,486.11	-15.9%
Газрын тос /мян.баррель/	7,624.1	6,388.6	6,876.1	4,105.86	-46.1%

Зэсийн баяжмал, металл агуулгаараа /мян.т/	1,317.6	1,310.8	1,262.4	1,276.75	-3.1%
Алт /т/	19.8	20.7	16.3	20.2	1.9%
Төмрийн хүдэр /мян.т/	7,694.7	6,225.4	8,572.2	9,224.42	19.9%
Цайрын баяжмал /мян.т/	82.7	87.9	83.1	76.29	-7.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
*Урьдчилсан гүйцэтгэл

Зураг 13: Уул уурхайн салбарын экспортын бүтэц, хувь, 2020 он



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, геологи эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор мэргэжлийн багаар гүйцэтгүүлэх бодлогыг баримтлан ажиллаа. Энэ хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 40.5 хувийг 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн судалгаанд бүрэн хамруулав. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулсан геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К хавтгай хэмжээнд хээрийн судалгааны ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Монгол орны геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг Монгол орны баруун, баруун өмнөд, зүүн өмнөд хэсэгт гүйцэтгэж, нийт талбайн 31.3 хувьд хээрийн судалгааны ажлыг хийгээд байна.

Томоохон хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгаа болон сэдэвчилсэн судалгааны ажлын хүрээнд “Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи - 2017”, “Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа”, “Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа”, “Голлох ашигт малтмалын судалгаа” зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байна.

Мөн “Алт-2” үндэсний хөтөлбөрийг 2016 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд хээрийн судалгааны ажлыг 521,200 км² талбай буюу нийт нутаг дэвсгэрийн 33.3 хувьд гүйцэтгэж, алтны хүдэржилт бүхий талбай, дүүрэг, зангилаа, түүнд тогтоогдсон орд, илрэл, эрдэсэжсэн цэг, сарнилын хүрээ бүхий хэсгүүдийг нарийвчлан тодорхойллоо.

Уул уурхайн салбарт хэрэгжиж томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллаа.Үүнд:

1. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил 64 хувьд хүрээд байна. Энэ хүрээнд үйлдвэрлэлийн 2 дугаар босоо амыг барьж дуусгасан ба далд уурхайн хөндлөн малталт 30,923 кв.м3, налуу буюу конвейрийн малталт 8.299 кв.м3, босоо ам 3 нэвтрэлтийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж байна.

2. Тавантолгойн орд ашиглалтыг өргөжүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Тавантолгойн ордын Бортээг болон Оорцогийн хэсэгт нарийвчилсан хайгуул, судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

3. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж, гэр хорооллын 220 мянган айл, өрхийг шахмал түлшээр бүрэн хангаж ажилласан.

4. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа хувьцааны хоёр дахь зах зээлийн арилжааг хөрөнгийн бирж дээр үе шаттайгаар эхлүүлэхтэй холбогдуулан зохион байгуулах ажлыг баталсан бөгөөд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой ХК”-ийн охин компани “Эрдэнэс - Тавантолгой Майнинг” ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Газрын тос боловсруулах үйлдвэр” байгуулах төслийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.Үүнд:

1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд үйлдвэрийн гаднах дэд бүтцийн ажлууд болох “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18.2 км урт цахилгаан хангамжийн 110 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 Кв-ын 6.3 МВт-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станцыг барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгөөд байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралтыг ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэл болон Байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг хийж гүйцэтгээд байна.

3.Үнэт металл боловсруулах, цэвэршүүлэх үйлдвэрийн урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан батлуулаад байна.

1.1.8. Эрчим хүчний салбар

Монгол Улсын эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор “ДЦС-3-ын суурилагдсан хүчин чадлыг 75 мВт-аар өргөтгөх”, “Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх”, Улаанбаатар хотын “Амгалангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх”, “Тавантолгойн 300 МВт-ын цахилгаан станцыг барих”, “Багануурын 400 МВт-ын ДЦС барих”, “Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих”, “Эрдэнбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих”, “Төвийн бүсийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих” төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээг авч ажиллаа.

Хүснэгт 5. Цахилгаан, дулаан үйлдвэрлэл

	Нэгж	2017	2018	2019	2020*
Цахилгаан эрчим хүч	сая квт.цаг	6,027.3	6,535.3	6,900.4	6,254.3


Дулааны эрчим хүч	мян.Гкал	11,296.4	11,504.8	13,277.3	12,566.7
-------------------	----------	----------	----------	----------	----------

**Урьдчилсан гүйцэтгэл*

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол улсын хэмжээнд 2017 онд 6,027.3 сая кВт.цаг эрчим хүч, 11,296.4 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж байсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6,254.3 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч, 12,566.7 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, 2017 онтой харьцуулахад цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 3.8 хувиар, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл 11.2 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 14. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн бүтэц, хувиар, 2020 он



Эх сурвалж: Эрчим хүчний яам

**Урьдчилсан гүйцэтгэл*

Дотоодын цахилгаан эрчим хүчний 89.9 хувийг дулааны цахилгаан станц, үлдсэн 10.1 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүрдүүлж байна. Дулааны цахилгаан станцуудыг хүчин чадлыг өргөтгөн, шинэчлэх чиглэлээр Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг 35 МВт-аар өргөтгөх төслүүдийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, барилга угсралтын ажлыг эхлүүлж, ашиглалтад хүлээн авахаар ажиллаж байна.

Мөн Дулааны 2-р цахилгаан станцын хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөх төсөл, Амгалангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх төслүүдийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, Дулааны 3-р цахилгаан станцыг хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх төсөл, Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх төслүүдийн барилга, угсралтын ажлыг эхлүүлэхээр тус тус ажиллаж байна.

Шинээр эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд 2017-2020 онд Эрдэнэтийн Уулын баяжуулах үйлдвэрийн дулааны цахилгаан станцын хүчин чадлын 48 МВт-аар нэмж, Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт 10 МВт-ын нарны станц, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 10 МВт-ын нарны цахилгаан станц, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт дэвсгэрт 50 МВт-ын хүчин чадалтай салхин цахилгаан станц, Дорноговь аймгийн Сайншанд суманд “Сайншанд салхин парк” ХХК-ийн 52 МВт-ын салхин цахилгаан станцуудыг барьж, ашиглалтад орууллаа. Мөн, Бүгд найрамдах

Солонгос Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 10 аймагт Дулааны цахилгаан станц шинээр барих төслийг хэрэгжүүлж байна.

Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэх чиглэлээр Эрдэнэбүрэнгийн 90 МВт усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлж байна. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх төсөл”-ийг тус тус хэрэгжүүлж байна.


Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж байгуулах ажлын хүрээнд “Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт 260 км ЦДАШ, 220 кВ-ын дэд станц барих, Оюутолгой, Тавантолгой дэд станц”-ын барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад хүлээн авав.

1.1.9. Хөдөө аж ахуйн салбар

Мал аж ахуй. Монгол Улс 2017 онд 66.2 сая толгой малтай байсан бол 2020 онд 67.1 сая толгой мал тоологдож тус өсөлт 1.3 хувь болсон байна. Тус хугацаанд ямаа 372.4 мянган толгой буюу 1.4 хувиар, хонь 845.3 мянган толгой буюу 1.3 хувиар, үхэр 343.2 мянган толгой буюу 7.8 хувиар, адуу 153.3 мянган толгой буюу 3.9 хувиар, тэмээ 38.8 мянган толгой буюу 8.9 хувиар өссөн байна.

Малчин өрхийн хувьд 2020 онд 2017 онтой харьцуулахад 50 хүртэлх малтай өрх 3.2 пунктээр, 51-200 хүртэлх малтай өрх 12.3 пунктээр, 201-500 малтай өрх 4 пунктээр, 501-999 малтай өрх 2.8 пунктээр өссөн бол, 1000-аас дээш малтай өрх 10 пунктээр буурсан байна.

Зураг 15. Малтай өрхийн тоо, малын тооны бүлэглэлээр



*Урьдчилсан гүйцэтгэл

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 6. Монгол Улсын малын тоо /мянган толгой/

Малын төрөл	2017	2018	2019	2020*
Тэмээ	434.1	459.7	472.4	472.9
Адуу	3,939.40	3,940.00	4,214.80	4,092.71

Үхэр	4,388.20	4,380.80	4,753.20	4,731.39
Хонь	30,108.00	30,554.80	32,267.30	30,045.59
Ямаа	27,346.10	27,124.40	29,261.70	27,718.52
Бүгд	66,215.80	66,460.10	70,969.30	67,061.11

*Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Газар тариалан. Газар тариалангийн салбар нь хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 12.8 хувийг эзэлж, Монгол Улсын нийт ажиллах хүчний 10 орчим хувь нь энэ салбарт хамаарч байна. Улсын хэмжээгээр нийт үр тарианы 1490, төмс, хүнсний ногооны 370 аж ахуйн нэгж, 35 мянган өрхийн тариалан эрхлэгчид газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд 2020 онд нийт 587.9 мянган га талбайд тариалалт хийснээс 430.3 мянган тонн үр тариа, 244.3 мянган тонн төмс, 121.2 мянган тонн хүнсний ногоо, 1.19 сая тонн бэлтгэсэн хадлан, 42.2 мянган гар тэжээл бэлтгэсэн байна.

Хүснэгт 7. Хураан авсан ургацын хэмжээ /тонн/.

	2017	2018	2019	2020*
Үр тариа	238 101.9	453 849.2	433 305.4	430 317.9
Буудай	231 364.4	436 114.9	411 414.8	406 129.1
Төмс	121 808.5	168 882.6	192 239.9	244 261.6
Хүнсний ногоо	82 102.0	100 731.7	99 546.6	121 235.2
Бэлтгэсэн хадлан	1 008 145.6	1 229 424.8	1 369 212.5	1 186 170.5
Бэлтгэсэн гар тэжээл	52 288.1	51 690.7	58 440.2	42 194.4

*Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Боловсруулах үйлдвэрлэл. Боловсруулах аж үйлдвэрийн салбар 2020 урьдчилсан гүйцэтгэлээр аж үйлдвэрийн салбарын 21.3 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд урьдчилсан гүйцэтгэлээр 3.9 их наяд төгрөгт хүрч, 2017 онтой харьцуулахад 1.43 их наяд төгрөгөөр буюу 56.8 хувиар өслөө. Хөнгөн үйлдвэрийн салбар нь ноос ноолуур, арьс шир, мод модон тавилга, оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл, барилгын материал, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, цахилгаан бараа, гоо сайхан, эм, ахуйн химийн болон бэлэг дурсгалын үйлдвэрлэл зэрэг дэд салбарыг хамарч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 8. Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020*
Самнасан ноолуур	Мянган тонн	1101.8	1160.3	774	516.4
Тэмээний ноосон хөнжил	мянган метр	30.2	9.4	9.9	91.8
Эсгий	мянган метр	114.9	112.1	187.4	264.9
Хивс	мянган метр	497.9	528.2	478.3	695.7
Эсгий гутал	мянган хос	0.3	0.4	0.6	0.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
*Урьдчилсан гүйцэтгэл

Монгол Улсын стратегийн түүхий эд болох ноолуурын салбарын хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, ашиглалтыг

нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг дээшлүүлэх, хүчин чадал нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх, үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийг шийдвэрлэх, гадаад зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Ноос, ноолуур боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 үйл ажиллагаа явуулж, угаасан ноос, ноолуурыг БНХАУ-д, самнасан ноолуурыг Итали, Англи, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ, ХБНГУ, БНСУ, Япон, Бельги, Франц зэрэг 20 гаруй оронд экспортолсон.

Жижиг дунд үйлдвэрлэл. Монгол Улсад өнөөгийн байдлаар бүртгэлтэй нийт 200.5 мянган аж ахуйн нэгж байгаагаас 94.5 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрийн салбарт 50.1 хувь нь ажиллаж байна.

Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн орчныг сайжруулах зорилтын хүрээнд 2019 онд Зээлийн батлан даалтын сангийн тухай, Татварын багц хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн албан татварын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлтүүд орж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 362 дугаар тогтоолоор “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”, Засгийн газрын 2019 оны 418 дугаар тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”-ийг тус тус батлав. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулав.

1.2. САНХҮҮГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Санхүүгийн салбарын нийт активын хэмжээ 2017 онд 32.5 их наяд төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 42.3 их наяд төгрөгт хүрч 9.8 их наяд төгрөгөөр буюу 30.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Санхүүгийн салбарын тогтвортой өсөлтийг баталгаажуулах, санхүүгийн дэд салбарууд эн тэнцвэртэйгээр хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, хямралаас урьдчилан сэргийлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилго бүхий “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.


1.2.1. Банкны салбар

Банкны салбарт 2020 оны жилийн эцсийн байдлаар 12 арилжааны банк 1,402 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Банкнуудын олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2017 онд 18.8 хувь байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 4 нэгж хувиар буурч 14.8 хувь болсон. Харин валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2020 оны жилийн эцсийн байдлаар 9.4 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлж, банкнуудад “Активын чанарын үнэлгээ” хийж, үнэлгээний үр дүнд зарим арилжааны банкнуудад өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагыг хүргүүлсэн. Монголбанкнаас 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Капитал банкныг албадан татан буулгах шийдвэр гаргаж, эрх хүлээн авагч томилон ажиллуулж байна. Мөн Худалдаа Хөгжлийн банк, Улаанбаатар банкнууд нэгдэх үйл ажиллагаа явагдсан.

Активын бүтэц, өөрчлөлт. Банкны салбарын нийт активын хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 36.7 их наяд төгрөгт хүрч, 2016 онтой харьцуулахад 31 хувиар буюу 11.4 их наяд төгрөгөөр нэмэгдэж, ДНБ-ийн 97.1 хувьд хүрээд байна. Нийт активын 48.2 хувь нь зээл, 12.5 хувь нь банкны нөөц, 1.7 хувь нь Засгийн газрын авлага, 21.7 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 13.6 хувь нь бусад хөрөнгө байна (гадаад актив, үнэт цаас, бусад санхүүгийн байгууллагаас авах авлага, ӨБҮХХ, дериватив, үндсэн, биет бус хөрөнгө, үнэт металл). Банкны салбарын зээлийн хэмжээ 2020 оны эцэст 17.7 их наяд төгрөгт хүрч, 2016 оноос 45.1 хувиар буюу 5.5 их наяд төгрөгөөр нэмэгдлээ.

Зураг 16. Нийт активын бүтэц /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарт 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 17,034.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 13,767.5 тэрбум төгрөг буюу 80.8 хувь нь хэвийн ангилалд, 1,264.5 тэрбум төгрөг буюу 7.4 хувь нь хугацаа хэтэрсэн ангилалд, 2,002.3 тэрбум төгрөг буюу 11.8 хувь нь чанаргүй зээлд тус тус ангилагдсан байна. Зээлийн чанарыг 2017 онтой харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 853.8 тэрбум төгрөгөөр буюу 74.3 хувиар нэмэгдсэн бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 445.1 тэрбум төгрөгөөр буюу 54.3 хувиар нэмэгдсэн байна.

Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2017 онд 8.5 хувь байсан бол 2020 онд 11.8 хувь болж өссөнөөс уул уурхайн салбарт 23.9 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 28.3 хувь байгаа нь дунджаас өндөр байна. Нийт зээлийн 50.1 хувийг эзэлж буй хэрэглээний зээлийн хувьд 2020 оны жилийн эцэст нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн харьцаа 5.8 хувьд хүрсэн байна.

Зураг 17. Чанаргүй зээл /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар авч үзвэл иргэдэд олгосон хэрэглээний зээл 8.5 их наяд төгрөг буюу нийт зээлийн 50.1 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарт 2.3 их наяд төгрөг буюу нийт зээлийн 13.4 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 2.7 их наяд төгрөг буюу нийт зээлийн 16.1 хувь, барилгын салбарт 1.5 их наяд төгрөг буюу нийт зээлийн 8.9 хувь, боловсруулах салбарт 1.4 их наяд төгрөг буюу нийт зээлийн 8.2 хувь, уул уурхайн салбарт 1.8 их наяд төгрөг буюу нийт зээлийн 10.3 хувь тус тус олгогдсон байна.

Пассивын бүтэц, өөрчлөлт. Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2020 онд 33.6 их наяд төгрөгт хүрч, 2017 оноос 8.0 их наяд төгрөгөөр буюу 31.1 хувиар өссөн байна.

Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн хэмжээ оны эцсийн байдлаар 3.1 их наяд төгрөгт хүрч, 2017 оноос 91.2 тэрбум төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан.

Зураг 18. Банкны салбарын пассивын үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын бодлогын арга хэмжээ. Монгол Улсын Засгийн газраас Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд банкны салбарт хууль, эрх зүйн шинэчлэлийг амжилттай хийж, зээлийн хүү болон чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зорилгоор “Зээлийн хүү бууруулах стратеги 2018-2023” болон “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар баталж, хэрэгжүүлж байна. Мөн УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаар тогтоолоор “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг баталсан бөгөөд тус стратегийн хүрээнд зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах арга хэмжээг авах талаар тусгасан.

- **Төвбанк /Монголбанк/-ны тухай хууль.** УИХ-ын чуулганы 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг баталсан. Энэхүү өөрчлөлтөөр “Мөнгөний бодлогын хороо” болон банкны хяналт шалгалтын шийдвэрийг гаргадаг “Банкны хяналт шалгалтын хороо”-г байгуулахаар, төсвийн шинж чанартай санхүүжилтийн хөтөлбөрийг Монголбанкнаас санхүүжүүлж, мөнгөний бодлогын зорилт үр нөлөөг алдагдуулдаг байдлыг арилгах зорилгоор Засгийн газарт зээл олгох, Засгийн газрын үнэт цаасыг

худалдан авах Монголбанкны үйл ажиллагааг тодорхой зааж, хязгаарлалтуудыг тус тус тусгасан.

- **Банкны тухай хууль.** УИХ-ын чуулганы 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар “Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцэн баталсан. Энэхүү өөрчлөлтөөр банканд тавих хяналт, Монголбанкны бүрэн эрх, албадлагын арга хэмжээ, “холбогдох этгээд”, “холбоотой этгээд”-ийн болон банкны зээлийн төвлөрлийн тодорхойлолт, банкнаас тэдгээртэй хийх хэлцлийн хязгаарлалтыг нарийвчлан зохицуулсан. Банкны хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх үүднээс эрсдэлийн түвшин, нөхцөл байдалд тохируулан төлөвлөх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бий болгож, хүндрэлд орсон банкны асуудлыг шийдвэрлэх “Бүтцийн өөрчлөлт хийх арга хэмжээ”, түүний хэрэгслүүдийг шинээр тодорхойлох, банкиг татан буулгах ажиллагааны журам, эрх зүйн үндэслэлийг сайжруулах, дээрх арга хэмжээний хүрээнд оролцогч этгээдийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн хяналтын хүрээг тодорхой болгож зохицуулсан.

Үүний дараа Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн УИХ-ын намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Энэхүү Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийг оруулснаар банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурч, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх ач холбогдолтой. Түүнчлэн арилжааны банкуудад хувьцаа эзэмшил, удирдлагын төвлөрсөн байдлаас үүдэлтэй эрсдэл буурч, банкны хувьцааны эзэмшил, мэдээллийн хүртээмжээр дамжуулан олон нийтийн хяналт бий болох, зах зээлийн дохиолол бүрдэх, банкны хяналт шалгалтын бие даасан байдал нэмэгдэхээс гадна хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэгээр нөлөөлөх олон давуу талыг бий болгоно.

- **Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль.** Хадгаламжийн даатгалын хууль, эрх зүйн орчныг олон улсын стандарт, зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг УИХ-ын 2018 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. “Банкны тухай” хуулийн шинэчлэлтэй уялдуулан банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилготой банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлж болох, Хадгаламжийн даатгалын корпорацаас банканд хэрэгжүүлэх хяналт шалгалт, эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох, даатгалын тохиолдлын үед хадгаламж эзэмшигчийн даатгалын нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулж, нэмэгдүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтийг тусгасан.
- **Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга.** УИХ-ын чуулганы 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Хуульд Хөгжлийн банкиг төсвийн хамрах хүрээнээс ангид байх, хараат бус бие даасан шийдвэр гаргадаг байх, 100 хувь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байх, төсөл хөтөлбөрүүд нь арилжааны нөхцөлтэй, санхүүгийн үр ашигтай, хэрэгжүүлсэн төслөөс эргэн төлөгдөх чадвартай байхаар тус тус тусгасан. Мөн Хөгжлийн банкны үйл ажиллагаанд Монголбанкнаас хяналт шалгалт хийж, тус банкны санхүүгийн зохистой харьцааг хянаж


байхаар зохицуулснаас гадна үйл ажиллагаанд нь сайн засаглалын зарчмыг баримтлахаар хуульд тусгасан байна.

- **Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль.** УИХ-ын чуулганы 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай” хуулийг хэлэлцэн баталсан. Тус хууль нь анхдагч хууль бөгөөд хуулиар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, ирээдүйд төрөөс гарч болзошгүй их хэмжээний зардлыг бууруулах зорилгоор арилжааны банкнуудад хийгдсэн активын чанарын үнэлгээний үр дүнд өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан системийн нөлөө бүхий банкнуудын өөрийн хөрөнгийг хувьцаа эзэмшигч, бусад хөрөнгө оруулагчаар хангуулах, шаардлагатай бол төрөөс дахин хөрөнгөжүүлэх, оруулсан хөрөнгийг удирдах, төсөвт буцаан төвлөрүүлэх харилцааг зохицуулсан.
- **Арилжааны банкнуудад хийгдсэн “Активын чанарын үнэлгээ”.** “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд арилжааны банкнуудын үйл ажиллагааны чадамж, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээг тогтоох зорилгоор “Активын чанарын үнэлгээ”-г 2018 онд хийсэн. Үнэлгээний үр дүнгээр банкны салбар 500 гаруй тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгийн дутагдалтай гарч, дутагдалтай банкнуудад өөрийн хөрөнгөө 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор шаардлагатай хэмжээнд нэмэгдүүлэх хугацаат үүргийг Монголбанкнаас өгсөн. ОУВС-аас өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг баталгаажуулах шаардлага тавьсны дагуу форензик аудитын шалгалт хийж, шаардлага хангасан эх үүсвэрээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх хугацаат үүрэг өгсөн.
- **Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль.** Дэлхий дахинд Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын цар тахлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ыг баталсан. Тус хуулийн хүрээнд банкны харилцах дансанд хүү тооцохгүй, гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй бөгөөд иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай зохицуулалтыг тусгасан.

1.2.2. Хөрөнгийн зах зээл

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 53 үнэт цаасны компани хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн зах зээл дээр үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 2, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 23, хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын 14 этгээд тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 19. Үнэт цаасны компаниуд




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээлийн үндсэн үзүүлэлт. Монгол Улсын санхүүгийн зах зээлийн нийт актив хөрөнгө 2020 оны жилийн эцсийн байдлаар 40.8 их наяд төгрөг байгаагаас хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 3.0 их наяд төгрөг буюу санхүүгийн зах зээлийн 8.2 хувийг эзэлж байгаа нь 2017 онтой харьцуулахад нийт активын хэмжээ 18.6 хувиар, санхүүгийн зах зээлд эзлэх хувь 3.0 пунктээр өссөн байна. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 3.0 их наяд төгрөг болж, ДНБ-ний 8.1 хувьтай тэнцэх болсон нь 2017 оноос макро эдийн засгийн нөхцөл байдал сэргэж, бизнесийн таатай орчин үүссэн, гадаадад бүртгэлтэй байгаа нээлттэй хувьцаат компаниудад Монголын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн, компаниуд хөрөнгийн зах зээлээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд санал болгож эхэлсэн зэрэгтэй холбоотой юм.

Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны биржээр дамжин 2020 онд нийт 65.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд үүнээс 82.5 хувийг хувьцаа, 7.8 хувийг хөрөнгө оруулалтын сан, 8.9 хувийг компанийн бонд, 0.9 хувийг засгийн газрын үнэт цаас тус тус бүрдүүлж байна. Мөн хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар 2020 оны жилийн эцсийн байдлаар 1.8 хувь болж 2017 онтой харьцуулахад 1.4 пунктээр буурсан байна.


Зураг 20. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээл 2017 оноос хойш идэвхжиж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 11 хувьцаат компани, Монголын үнэт цаасны биржээр дамжуулан 1 хувьцаат компани олон нийтэд хувьцаагаа санал болгон, нийт 77.7 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна


Зураг 21. Үнэт цаасны нийт арилжаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ТОП-20 индекс 2017 онд 20,736.9 нэгж байсан бол 2020 онд 19,285.8 нэгж болон 7.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 22. ТОП-20 индекс /нэгжээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монголын хөрөнгийн биржид 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 192 ХК бүртгэлтэй байгааг 2017 онтой харьцуулахад 26 компаниар буурсан. Ийнхүү бүртгэлтэй компанийн тоо буурсан нь үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ сүүлийн 3-аас дээш жилийн хугацаанд тогтмол биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг хасах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж буйтай холбоотой юм.

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хүрээнд “МИК ОССК” ХХК-аас 24 ТЗК үүсгэн байгуулж, нийт 83,674 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-нд бүртгүүлээд байна.

Монгол Улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үл хөдлөх хөрөнгийн зээлээр баталгаажуулж ирсэн бөгөөд 2020 оны байдлаар нийт 64,553 зээлдэгчийн 3.0 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаас байна. Мөн үүрэн телефоны оператор болох “Жи-Мобайл” ХХК хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаажсан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон байна.

Ковид-19 цар тахлын онцгой нөхцөлд ажиллаж буй төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны хөтөлбөрт хамруулах хүрээнд түрээсийн орлогод суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхийг хууль болон УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор ЗГ, Монголбанк, Хороонд даалгасан. Хорооноос “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн үүсгэн байгуулсан “НОСК нэг” ХХК-д түрээсийн орлогоор баталгаажсан буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгож, орон сууцны түрээсээр баталгаажсан 34.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн. Мөн Хорооноос “НОСК хоёр” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгоод байна.

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжүүлэх дэд арга хэмжээний 1.4.1-д “Уул уурхайн бус экспорт

болон жижиг, дунд үйлдвэрийн салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг банкнаас олгосон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах, уг үнэт цаасыг барьцаалан Төв банкны репо санхүүжилтийг 1-2 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй ойролцоо хүүтэй санхүүжилтийн эх үүсвэр олгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. Дээрх зээлийн хүүг бууруулах стратегийн дэд арга хэмжээг Монголбанк болон Хороо хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан. Энэхүү ажлын хүрээнд “МҮЦСК” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, “Монголын Актив Удирдлагын Корпораци” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон.

Хорооноос “Инвекор актив” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгож, гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн нь банк бус санхүүгийн байгууллагуудын зээлээр баталгаажсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд анх удаа нээлттэй арилжаалах анхны тохиолдол болсон.

- **Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн үнэлгээ.** Сангийн яам 2017 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран “Хөрөнгийн болон мөнгөний зах зээлийн үнэлгээ”-ний төслийг хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд богино хугацаанд нэн тэргүүнд яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай 2 арга хэмжээний зөвлөмжийг өгсөн. Энэ нь нэгдүгээрт, “Хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах”, хоёрдугаарт, “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системд Олон улсын төлбөр тооцооны суурь зарчим болох DvP/T+2 буюу Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ Төлбөр тооцоог арилжаа явагдсанаас хойш 2 дахь өдөрт гүйцэтгэх” зарчмыг нэвтрүүлэх зөвлөмж юм.
- **Хууль эрх зүйн орчны шинэчлэл.** Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 108 дахь хэсэгт “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах хороонд тус тус үүрэг болгосон. Энэ дагуу дагуу Сангийн сайдын 2019 оны 227 дугаар тушаалаар “Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, түүний үзэл баримтлал, тандан судалгааны хамт боловсруулаад байна. Энэхүү хуулийн шинэчлэлийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчныг уян хатан зохистой болгохыг зорьж байгаа бөгөөд зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэхэд таатай эрх зүйн орчин бүрдүүлэх, дэд бүтцийн олон улсын зарчмыг нэвтрүүлэхтэй холбоотой зохицуулалтыг шинээр тусгах, зах зээлд урт хугацаат мэргэжлийн хөрөнгө оруулагч бий болгох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулагч байгууллага хоорондын чиг үүргийн давхардлыг арилгах зэрэг өөрчлөлтүүдийг тусгаж байгаа болно.
- **Олон улсын төлбөр тооцооны стандарт-Төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ дараа төлбөрт горимд шилжих.** Манай улсын хөрөнгийн зах зээлийн үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны горим нь олон улсын санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчим (PFMI буюу Principal for Financial Market Infrastructure)-ийг хэрэгжүүлдэггүйгээс гадаадын хөрөнгө оруулагч хөрөнгийн зах зээлд орж ирэхэд хүндрэлтэй, арилжааны төлбөрийг 100 хувь урьдчилж байршуулдаг нь хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийг гацаах, шат дамжлага, зардал нэмэх зэрэг хүндрэлүүдийг үүсгэдэг. Хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцооны горимыг олон улсын стандартад нийцүүлэх бодлогын арга

хэмжээний хүрээнд 2020 оны 3 дугаар сарын 31-ны өдрөөс эхлэн олон улсын төлбөр тооцооны “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP)/T+2” горимыг нэвтрүүлээ.


- **Монголын бондын гарын авлага.** Монгол Улс нь санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжилтэй хөл зэрэгцэж, олон улсын сайн туршлага, стандартуудыг нэвтрүүлэх зорилгоор Зүүн өмнөд Азийн орнууд болон Япон, Солонгос, БНХАУ-ыг хамарсан АСЕАН+3-ийн “Азийн бондын зах зээлүүд санаачилга”-д ажиглагчаар 2018 оны 5 сард элссэн. Энэхүү санаачилгын хүрээнд 2019-2020 оны хооронд АХБ-ны техник туслалцааны дэмжлэгээр “Монголын бондын гарын авлага”-ыг боловсруулан АХБ-ны цахим хуудсанд байршуулаад байна.

1.2.3. Даатгалын зах зээл

Даатгалын зах зээл дээр 2020 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын 14 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 1 компани, даатгалын 56 зуучлагч, даатгалын 25 хохирол үнэлэгч, даатгалын 2473 төлөөлөгч, 32 актуарч, даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын 45 компани тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлт. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар даатгалын нийт хураамжийн орлого ДНБ-ийн 0.57 хувьтай тэнцүү байна.

Зураг 23. Даатгалын нягтрал болон нэвтрэлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгө, хураамжийн орлого. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 382.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 2017 онтой харьцуулахад 137.3 тэрбум төгрөг буюу 56.1 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого, түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн эзлэх хувийг салбарын хэмжээнд авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 82.97

хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 14.46 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 2.57 хувийг тус тус эзэлж байна.

Даатгалын компаниуд 2020 онд нийт 205.1 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлснээс ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 201.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан байна. Үүний 200 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг буюу 99.3 хувийг ердийн даатгалын компаниуд, 1.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг буюу 0.7 хувийг урт хугацааны даатгалын компани тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 24. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлт /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өр төлбөр, нөөц сан, эздийн өмч. 2020 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын нийт өр төлбөр 200.7 тэрбум төгрөгт, даатгалын нөөц сан 173.5 тэрбум төгрөгт, эздийн өмч 181.3 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Ердийн даатгалын компаниудын хувьд нийт өр төлбөр ба эздийн өмчийн 53.9 хувийг өр төлбөр, 27.6 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц, 17.9 хувийг нөхөн төлбөрийн нөөц сан, 46.1 хувийг эздийн өмч тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 9. Даатгалын компаниудын өр төлбөр, нөөц ба эздийн өмч 2020 он /сая төгрөг/

Компани	Өр төлбөр	Нөөц сан	Эздийн өмч	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц
Ердийн даатгалын компани	170,962.3	56,700.2	146,054.0	87,411.3
Урт хугацааны даатгалын компани	2,899.0	2,831.0	6,917.7	
Давхар даатгалын компани	26,884.1	26,575.9	28,354.7	
НИЙТ	200,745.5	86,107.1	181,326.5	87,411.3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөхөн төлбөр, хохирлын харьцаа. Даатгалын тохиолдлын улмаас урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд 2020 онд нийт 59.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Хохирлын харьцаа ердийн даатгалын компаниудын хувьд 46.8 хувь, урт хугацааны даатгалын компанийн хувьд 62 хувь байна.

Хүснэгт 10. Даатгалын компаниудын нөхөн төлбөр /сая төгрөг/

№	Даатгалын компанийн төрөл	Нийт нөхөн төлбөр /сая.төг/	Салбарт эзлэх хувь
		2020	
1	Ердийн даатгалын компани	59,245.7	99.0%
2	Урт хугацааны даатгалын компани	582.1	1.0%
НИЙТ		58,827.8	100.00%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Албан журмын даатгал. 2020 онд ердийн даатгалын 14 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлж 34.6 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Ердийн даатгалын хураамжийн 17.3 хувийг албан журмын даатгал бүрдүүлж байна.

Хууль эрх зүйн орчин.

- ❖ Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийн үзэл баримтлал батлагдсан.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж, хуулийн төслүүдийн үзэл баримтлалын төсөлд Сангийн яаманд тухай бүр саналыг хүргүүлж ажилласан бөгөөд 2020 оны 4 дүгээр сард эдгээр хуулиудын төслийн үзэл баримтлал батлагдсан.

- ❖ Хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгох хүрээнд холбогдох хуулийн төслүүдэд санал хүргүүлж ажиллав.

Азийн хөгжлийн банкны ажлын хэсгээс боловсруулсан Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын санаачилсан “Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл”-д тухай бүр холбогдох саналыг хүргүүлж ажилласан.

2. “Даатгалын багц дүрэм”-ийн холбогдох журам, зааврыг шинэчилж, нэмэлт, өөрчлөлт оруулав:

- Даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг илүү ёс зүйтэй, шударга өрсөлдөөнтэй болгох замаар даатгуулагч олон нийтийн даатгалын салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг шинэчлэн боловсруулж Хорооны 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.
- Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт” болон арван гуравдугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын

төлөвлөгөөнд тавигдах шаардлага"-ыг шинэчлэн боловсруулж, Хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор баталлаа.

- ❖ Хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр “Даатгалын багц дүрэм”-ийн холбогдох дүрэм, журмыг шинэчлэн найруулав.
 - Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” болон дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулсан.
- ❖ Шинэчлэгдэн батлагдсан эрх зүйн орчинтой нийцүүлэн холбогдох журам, заавруудыг шинэчлэн боловсруулж, батлуулж, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж ажиллав. Үүнд:
 - Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 6/10 тоот тушаалаар “Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ыг, 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 5/11 тоот тушаалаар “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”-ыг тус тус шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4673, 4674 дугаарт бүртгүүлсэн.
 - Хорооны 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 165, 166 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тус тус баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3947, 3948 дугаарт тус тус бүртгүүлсэн.

3. Гадаад, харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллав:

- ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ (MEFIN)-тэй хамтран даатгалын салбарын технологийн дэвшил, хүртээмжтэй даатгалын зохицуулалтыг сайжруулах, уур амьсгал, гамшгийн эрсдэлийг бууруулах, нягтлан бодох бүртгэлийн шинэ стандарт /IFRS-17/-ыг хэрхэн нэвтрүүлэх зэрэг чиглэлүүдээр зохион байгуулсан цахим сургалт, хэлэлцүүлгүүдэд тухай бүр оролцож байна.

- Олон улсын даатгалын холбоо (IAIS)-ны гишүүн орнуудын ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон түүний үр дагаврын талаарх ирүүлсэн судалгааг боловсруулсан бөгөөд уг судалгаанд Монгол Улсын даатгалын салбарт үүсээд нөхцөл байдал, түүнийг даван туулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар мэдээллийг хүргүүлж, мөн бусад улс орнуудад хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн мэдээллийг авч, мэдээлэл солилцон ажилласан бөгөөд мөн тус холбооноос байгуулсан даатгалын компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл, зах зээлийн чиг хандлага, цахим эрсдэл болон гуравдагч этгээдээр дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, түүнээс үүсэх эрсдэл зэргийг судалж, тухайн эрсдэлүүд нь даатгалын компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, уг нөлөөллийг хэрхэн бууруулах боломжийн талаар судлах зорилго бүхий “Даатгалын үйл ажиллагааны уян хатан байдлыг хангах” ажлын хэсэгт орж ажиллаж байна.

4. Даатгалын салбарын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх” эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэв:

- МУТС үндэсний эрсдэлийн үнэлэх ажлын хүрээнд Дэлхийн банкнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу даатгалын салбарын мөнгө угаах эрсдэлд өртөмтгий байдал болон хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүний мөнгө угаах эрсдэлийг үнэлж, уг үнэлгээний тайланг боловсруулсан

- Даатгалын салбарын МУТС мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох гарын авлагыг бэлтгэсэн.


5. Даатгалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдох ажлуудаас онцолбол:

- Зохицуулалтын байгууллагуудаас ирүүлэх хүсэлтүүдийг цахимаар буюу зөвшөөрлийн системээр хүлээн авч, шийдвэрлэж эхлээд байгаа ба Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд “Үндэсний амьдралын даатгал” ХХК, “Мандал даатгал” ХК, “Ард даатгал” ХК-с боловсруулсан Ковид-19 вирусийн эрсдэлээс хамгаалах даатгалын бүтээгдэхүүнүүдийг шуурхай хянан бүртгэж, уг бүтээгдэхүүнүүдтэй холбогдох мэдээллийг иргэд, олон нийтэд Хорооны цахим хуудсаар болон бусад нийтийн цахим сүлжээгээр дамжуулан хүргэсэн.

1.2.4. Бичил санхүү

Банк бүс санхүүгийн байгууллага. ББСБ-ын нийт активын хэмжээ 2020 онд 2.0 их наяд төгрөгт, нийт олгосон зээлийн хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрснийг 2017 оны нийт активын хэмжээ болох 969.2 тэрбум төгрөг, нийт олгосон зээл болох 638.0 тэрбум төгрөгтэй харьцуулахад тус тус 107.1 болон 108.0 хувиар өссөн дүнтэй байна. Нийт активын 96.1 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бөгөөд үүнээс 66.1 хувийг зээл, 24.5 хувийг мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.

Зураг 25. Нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ын 2020 оны нийт активыг 2019 оны ДНБ-ийн гүйцэтгэлтэй харьцуулахад 5.4 хувьд, нийт зээлийн хэмжээг 2019 оны ДНБ-ийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3.6 хувьд хүрсэн байна. ББСБ-ын тоо 2020 оны байдлаар 532 болж буурсан нь 2017 онтой харьцуулахад 2-оор буурсан байна.

Хүснэгт 11. ББСБ-ын статистик үзүүлэлтүүд


Үндсэн үзүүлэлтүүд	2017	2020
ББСБ-ын тоо	534	532
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,039	8,869
Ажиллагсдын тоо	2,473	3,437
Салбар нэгжийн тоо	168	286
Харилцагчдын тоо	1,175,964	2,844,782
Нийт актив /тэрбум төгрөгөөр/	969.2	2,006.9
Нийт эзэмшигчдийн өмч /тэрбум төгрөгөөр/	758.2	1,450.7
Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөг/	39.2	146.9
Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөг/	14.9	20.8
Нийт орлого	195.9	408.8
Нийт зардал	129.1	254.0
Тайлант үеийн ашиг	66.8	154.8

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2020 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2.8 хувьтай байгаа бөгөөд өмнөх онуудаас буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны байдлаар харилцагчдын тоо 2017 оноос 1.7 саяар нэмэгдэхэд нөлөөлсөн голлох хүчин зүйлс нь санхүүгийн үйлчилгээнд техник технологи /финтек/ дээр суурилсан санхүүгийн үйлчилгээнүүдийг хэрэглэгчдэд олгож, цахим зээлийн үйлчилгээ нэвтрүүлж байгаатай холбоотой байна. Жишээлбэл финтек дээр суурилсан үйлчилгээ авсан харилцагчийн тоо 2,515,149 буюу нийт харилцагчийн 88.4 хувийг эзэлж байгаа нь уламжлалт үйлчилгээ авсан 258,255 харилцагч буюу 11.6 хувиас 7.6 дахин их байна.

Хадгаламж зээлийн хоршооны үзүүлэлтүүд. Хадгаламж зээлийн хоршоодын нийт активын хэмжээ 2020 оны байдлаар 255.9 тэрбум төгрөгт хүрснийг 2017 онтой харьцуулахад 67.2 хувиар өссөн байна.


Зураг 26. Нийт хөрөнгө ба өр төлбөр /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2020 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын тоо 249 болж 2017 онтой харьцуулахад 14.1 хувиар буурлаа. ХЗХ-ны гишүүдийн тоо 2020 оны жилийн эцэст 72.7 мянга байсан бол 2017 онтой харьцуулахад 30.6 хувиар өсжээ.

Зураг 27. ХЗХ-дын болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2020 оны байдлаар ХЗХ-дын нийт хадгаламж 182.2 тэрбум төгрөг болж 2017 онтой харьцуулахад 83.4 хувиар өссөн байна. Нийт ХЗХ-дын 94.8 хувь буюу 236 ХЗХ нь 182.2 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн бол үлдсэн 5.2 хувь буюу 13 ХЗХ нь огт хадгаламж татаагүй байна. Нийт хадгаламжийн 98.3 хувь нь хугацаатай хадгаламж, 1.7 хувь нь хугацаагүй хадгаламж байна.


Зураг 28. Нийт хадгаламж, түүний өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламжийн хэмжээгээр бүлэглэн хувааж харвал 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламж татсан 19 ХЗХ нь нийт 162.0 тэрбум төгрөг буюу салбарын 88.9 хувийг, 500 саяас 1 тэрбум төгрөг хүртэл хадгаламж татсан 7 ХЗХ нь нийт 4.6 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг, 500 саяас доош төгрөгийн хадгаламж татсан 223 ХЗХ нь нийт 15.5 тэрбум төгрөг буюу салбарын 8.5 хувийг эзэлж байна.

Зураг 29. Нийт хадгаламжид эзлэх хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн батлан даалтын сан. Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангаас 2020 оны жилийн

эцсийн байдлаар батлан даалт гаргуулахаар нийт 128 хүсэлт ирсэн бөгөөд үүнээс 75 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна.

Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 117.8 тэрбум төгрөг буюу 2017 оноос 5 дахин өссөн дүнтэй байна.


Зураг 30. Нийт хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан


Сангийн батлан даалтын үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 66.3 тэрбум төгрөгт, батлан даалттай зээлийн үлдэгдэл 127.0 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Зураг 31. Батлан даалтын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Зураг 32. Шинээр гаргасан батлан даалт, эдийн засгийн салбараар




Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

1.2.5. Монгол Улсын Хөгжлийн банк

Хөгжлийн банкны актив 2017 оны жилийн эцсийн байдлаар 3758.0 тэрбум төгрөг, зээлийн үлдэгдэл 2,427.0 тэрбум төгрөг, эзэмшигчийн өмч 1069.0 тэрбум төгрөг, алдагдал 175.0 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт актив 4,313.9 тэрбум төгрөг, зээлийн үлдэгдэл 2,987.0 тэрбум төгрөг, эзэмшигчийн өмч 1,020.1 тэрбум төгрөг, алдагдал 64.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 33. Балансын үзүүлэлт



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк

Хөгжлийн банкны үйл ажиллагааг сайжруулах хүрээнд Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу өөрийн хөрөнгийн хэмжээг 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж, Засгийн газрын 2016 оны 219 дугаар тогтоолын дагуу Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагыг харилцан суутгах замаар шийдвэрлэсэн.

Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг авч үзвэл өөрийн хөрөнгийн хүрэлцээ 10.5 хувиас багагүй байхаас 17.8 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 100 хувиас багагүй байхаас 277.7 хувь, нийт 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 6 хувиас багагүй байхаас 18.3 хувь, нийт урт хугацаат актив, тогтвортой эх үүсвэрийн харьцаа 80 хувиас багагүй байхаас 140.2 хувь байна. Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 2020 оны жилийн эцсийн байдлаар 22.3 хувь байна.

Хөгжлийн банк 2020 оны жилийн эцсийн байдлаар цахилгаан, хий, уур, агааржуулалтад 51.8 тэрбум төгрөг, тээвэр, агуулахын үйл ажиллагаанд 9.1 тэрбум төгрөг, уул, уурхайн олборлолтын үйл ажиллагаанд 33.0 тэрбум төгрөг, барилгын салбарт 74.2 тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрт 62.9 тэрбум төгрөг, санхүүгийн салбарт 140.3 тэрбум төгрөг, арилжааны банкуудаар дамжуулан 140.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Хүснэгт 12: МУХБ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


	Байвал зохих хэмжээ	2017 он	2018 он	2019 он	2020 он
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	>10.5%	33.6%	32.0%	26.4%	17.8%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>100.0%	365.0%	293.7%	220.6%	277.7%
Нээлттэй позицын харьцаа	>±5.5%	-35.9%	-42.6%	5.0%	12.6%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа	>6.0%	33.4%	32.2%	26.5%	18.3%
Урт хугацаат актив, тогтвортой эх үүсвэрийн харьцаа	>80.0%	151.2%	152.5%	125.4%	140.2%

Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк

1.2.6. Банкин дахь мөнгөн хадгаламжийн тогтолцоо

Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө 2020 оны 12 дүгээр сарын 31-ны байдлаар **568.76** тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүний **253.02** тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаар, **306.96** тэрбум төгрөгийг хураамжийн орлогоор төвлөрүүлснээс **19.72** тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан.

Зураг 34. Хадгаламжийн даатгалын сангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Хадгаламжийн даатгалын корпорац

Хадгаламжийн даатгалын хууль, эрх зүйн орчныг олон улсын стандарт, зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2018 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан. Төвбанкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд олон улсын жишигт нийцүүлэн Хадгаламжийн даатгалын корпорацыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг гишүүн болгосон.

Монголбанкны ерөнхийлөгчийн шийдвэрээр төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдаж, өөрийн хөрөнгийн дутагдалд орж татан буугдсан Капитал банкны хадгаламж эзэмшигчдэд “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-д заасны дагуу 44.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг Хаан банкаар дамжуулан олгосон.

1.3. ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН


1.3.1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2018 онд анх удаа 10.0 их наяд төгрөгийг давж байсан бол 2019 оны гүйцэтгэлээр 12.0 их наяд төгрөгт хүрлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 2016 онд 9,495.3 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 39.8 хувийг эзэлж байсан бол 2017 онд 9,017.3 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.2 хувь, 2018 оны гүйцэтгэлээр 9,317.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 29.0 хувь, 2019 оны гүйцэтгэлээр 11,661.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 31.6 хувийг, 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9,421.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 36.1 хувийг тус тус байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2016 онд 3,660.3 тэрбум төгрөг, 2017 онд 1,742.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол 2018 онд 27.8 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь 2010 оноос хойш анх удаа нэгдсэн төсвийн тэнцэл ашигтай гарсан үзүүлэлт юм. Мөн 2019 оны гүйцэтгэлээр 756.2 тэрбум төгрөг, 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4,539.1 тэрбум төгрөгийн тус тус алдагдалтай тайлагнагдаж байна.

Зураг 35. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/



Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсөв. Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн орлогын гүйцэтгэл 5.8 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 405.9 тэрбум төгрөгөөр давж, нэгдсэн төсвийн зарлага 9.5 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 496.8 тэрбум төгрөгөөр дутуу гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцэл 3 их наяд 660.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, Дотоодын нийт бүтээгдэхүүний 15.3 хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 109.2 хувь, орон нутгийн төсвийн орлогын

биелэлт 99.1 хувь, хүний хөгжил сангийн орлогын биелэлт 111.4 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 103.3 хувь байна.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсөв. Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн орлогын гүйцэтгэл 7.3 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 591.1 тэрбум төгрөгөөр давж, нэгдсэн төсвийн зарлага 9.0 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 477.1 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна. Нэгдсэн төсвийн тэнцэл 1 их наяд 742.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, Дотоодын нийт бүтээгдэхүүний 6.4 хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 110.4 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 102.6 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 103.7 хувь байна.

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсөв. Төсөв, санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, төсвийг тодотгохгүйгээр мөрдүүлж, Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргахгүйгээр төсвийн санхүүжилтийг бүрэн олгож, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулсан жил болсон.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого анх удаагаа 10 их наядыг давж, 2018 онд 10,172.8 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь 2010 оноос хойш анх удаа юм.

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсөв. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого анх удаа 2019 онд 12 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 94.6 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 1,040.2 тэрбум төгрөгийг хуваарилж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 10,905.5 тэрбум төгрөг болсон.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 онд 10,905.5 тэрбум төгрөгт хүрсэн нь төлөвлөсөн дүнгээс 10.4 хувь буюу 1,023.5 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2018 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,560.4 тэрбум төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 11,661.7 тэрбум байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүний -2.0 хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн урьдчилсан гүйцэтгэл. Нэгдсэн төсвийн 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 93.7 хувийн, нийт зарлага 92.4 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт тэнцэл 4,539.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9,421.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 6.3 хувиар буюу 636.4 тэрбум төгрөгөөр дутаж, өмнөх оны мөн үеийнхээс 13.6 хувиар буюу 1,483.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15,106.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 13,960.8 тэрбум төгрөгийн буюу 92.4 хувийн, улсын төсвийн зарлага 11,653.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 10,859.4 тэрбум төгрөгийн буюу 93.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

1.3.2 Төсвийн зарлагад баримталсан бодлого, хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр, арга хэмжээ, бодлогын өөрчлөлт болон салбаруудад авч хэрэгжүүлсэн төсвийн бодлогын арга хэмжээ


Нэгдсэн төсвийн урсгал зарлагад 2016-2020 онуудад баримталсан бодлогын зорилт нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төсвийн орлогын боломжит эх үүсвэрт нийцүүлэн төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах замаар төсвийн тогтвортой байдлыг хангахад голлон чиглэгдэж ирсэн байна.

Тухайлбал, 2016-2017 онуудад, тэвчиж болох зардлуудыг бууруулах, хэмнэлтийн горимыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, төсвийн гадуурх зардлуудыг төсөвт нэгтгэх бодлого баримталж байсан бол 2018-2020 онуудын төсвийн бодлого нь цахим, ил тод, үр ашигтай төсвийн зарлагын реформ хэрэгжүүлэх, цар тахлын халдвараас сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэгдэж ирлээ.

Энэ хугацаанд 2016 онд 1 удаа, 2017 онд 2 удаа батлагдсан төсөвт тодотгол хийсэн бол 2018, 2019 онд батлагдсан төсөвт тодотгол хийгээгүй. Харин 2020 онд дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалтаас сэргийлсэн хорио цээрийн дэглэмийн улмаас эдийн засаг огцом хумигдаж, эхний хагас жилийн байдлаар -9.7 хувиар агшсан. Үүнтэй холбоотойгоор 2020 онд батлагдсан төсөвт тодотгол хийсэн. Тодотголууд нь ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т тохирсон өөрчлөлтүүдийг төсөвт тусгах, өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээнд нийцүүлж төрийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх шат дараалсан бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, нийт эрэлтийг дэмжихэд голлон чиглэгдсэн байна.

Төсвийн урсгал зардлын өсөлт 2016 оны гүйцэтгэлээр дунджаар 33.0 хувь байсан бол 2017 онд -5.0 хувь, 2018 онд 3.3 хувь, 2019 онд 25.2 хувь, 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр дунджаар 19.7 хувь болсон байна. Төсвийн урсгал зардлын өсөлт 2017-2018 онуудад буурсан шалтгаан нь ОУВС-ын хөтөлбөрт хамрагдаж төсвийн алдагдлыг бууруулахад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүчин зүйлс голлон нөлөөлсөн бол 2019-2020 онуудын өсөлт төсвийн зөв бодлого хэрэгжүүлж эдийн засгийн өсөлтийг бий болгосны үр дүнд хэрэгжүүлсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүн нөлөөлсөн, мөн халдварт цар тахлаас сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх шат дараалсан бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээс шалтгаалсан байна.

Зураг 36 . Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /тэрбум төгрөг/



Хэдийгээр дээрх хугацаанд зарлагын өсөлтийг хязгаарлах бодлого баримталсан хэдий ч хүн амын өсөлт, үнэ ханшны өөрчлөлт, нийгмийн үйлчилгээний салбарт хийгдсэн шинэ хөрөнгө оруулалтын ашиглалт, УИХ-аас шинээр баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон тоо, урсгал зардлыг тухай бүрт нь төсөвт тусгаж ирлээ.

Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газраас төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдагдлыг үе шаттай бууруулж өрийн дарамтыг арилгах, макро тэнцвэрийг хадгалах чиглэлээр төсөв, санхүүгийн бодлого баримталж байгаа боловч Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан зорилтуудыг төсөв, санхүүгийн боломжтой уялдуулан үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг 2016 оноос хойш төсөвт тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан дараах онцлог томоохон хөтөлбөр арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байна. Мөн дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалтаас сэргийлсэн хорио цээрийн дэглэмийн улмаас эдийн засаг огцом хумигдсантай холбоотойгоор халдварт цар тахлаас сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх шат дараалсан бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1/ Хүүхдийн мөнгө хөтөлбөр: ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт тохирсон бодлогын арга хэмжээг үндэслэн “хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг 2017 онд нийт хүүхдийн 60 хувьд олгох, 2018 оны 1 сарын 1-ээс эхлэн нийт өрхийн амьжиргааны түвшин доогуур 40 хувьд, 2019 оноос хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд буюу 90 хувьд, 2020 онд хүүхэд бүрд буюу 1 сая 250 мянган хүүхдэд олгож байгаа бөгөөд дунджаар жилд 1019.0 мянган хүүхдэд 497.2 тэрбум төгрөг зарцуулж байна.

2/ Оюутны хөгжлийн зээл: Монгол улсын Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын дагуу Боловсролын зээлийн сангаас “Оюутны хөгжлийн зээл”-ийг арилжааны банкаар дамжуулан 2016 оны 4-р улирлаас эхлэн олгож байна. Боловсролын зээлийн сангаас дотоодын их дээд сургуульд элсэн суралцагч нийт 3537 мянга орчим оюутныг сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй, урт хугацааны зээлд хамрагдах нөхцөл бүрдэж, төлбөрийн дарамтгүй суралцах боломж бүрдэж 2016 оноос хойш нийт 522.0 тэрбум төгрөг хуваарилаад байна.

3/ Эрүүл мэндийн даатгалын сан, эрүүл мэндийн салбарын зарим байгууллагыг бие даалгах: Эрүүл мэндийн санхүүжилт нь иргэдэд хүргэх тусламж үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн тогтолцоог бүрдүүлэх үүднээс 2018 оноос эхлэн Эрүүл мэндийн даатгалын сан бие даан үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн төрийн өмчийн эмнэлгүүдийн бие даасан байдлыг хангах, санхүү, төсвийн талаарх шийдвэр гаргах эрх мэдлийг тухайн эмнэлгийн удирдах зөвлөлд хариуцуулах, улсын төсвөөс санхүүжих эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэх бодлогын өөрчлөлтийг 2020 оноос эхэлж Улсын 3 дугаар төв эмнэлэг, Улсын 1 дүгээр төв эмнэлэг, Арьсны өвчин судлалын үндэсний төв хамрагдан хэрэгжиж эхэлж 2021 оноос лавлагаа шатлалын бүх эмнэлгүүд санхүүгийн хагас бие даасан хэлбэрт шилжиж үйл ажиллагаа явуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна..

4/ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх: Тухайлбал, анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэдэд үзүүлэх өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ болон анхан шатанд хийгдэх оношилгоо, шинжилгээний зардлыг 2018 оноос эхлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх бөгөөд үүнд жил бүр 8.7 тэрбум төгрөг зарцуулж байна. Мөн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ авахтай холбогдуулан учирч байгаа санхүү, төлбөрийн дарамтыг багасгах, гадаад улс орныг зорин эмчилгээ хийлгэхтэй холбогдуулан гадагш чиглэж байгаа эрүүл мэндийн төлбөрийн урсгалыг бууруулж дотооддоо шингээх, улмаар дотоодын эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадал, чадавхыг бэхжүүлэх зорилгоор даатгуулагч өндөр өртөгтэй, нарийн ур чадвар шаардсан мэс заслын эмчилгээ, тусламж үйлчилгээг хүртэх боломжийг нэмэгдүүлэхэд ЭМД-аас зарцуулах хөрөнгийг үе шаттай нэмэгдүүлж байна.

5/ “Цалинтай ээж” хөтөлбөр: Цалинтай ээж” хөтөлбөрийг 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Холбогдох хуулийн дагуу 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр, түүнчлэн гурав болон түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр тэтгэмж олгож, тэтгэмжийн хэмжээг хүүхдээ асарч байгаа эхэд сарын 50.0 мянган төгрөг буюу улиралд 150.0 мянган төгрөг, өрх толгойлсон эх/эцэгт улиралд 240.0 мянган төгрөгөөр буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгож байна.

6/ Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх: Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа бүх төрлийн тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2018, 2019, 2020 онуудад инфляцтай уялдуулан нэмэгдүүлэхэд жилд 148.7 тэрбум төгрөг нэмж зарцуулж байна.

7/ Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх: 2018, 2019, 2020 онуудад инфляцтай уялдуулан нэмэгдүүлэхэд жилд дунджаар 160.0 тэрбум төгрөг нэмж зарцуулж байна. Мөн 2020 онд төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлж эхлэв.

8/ Төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл олгох: Төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оноос эхлэн олгож эхэлсэн бөгөөд жилд 142.7 тэрбум төгрөг нэмж зарцуулна.

9/ Малчны тэтгэвэрт гарах насыг 5 жилээр наашлуулах: Нийт 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгох хуулийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хэрэгжүүлж эхэлснээр эрэгтэй 54-58, эмэгтэй 49-53 насны бүлгийн нийт 13.5 мянган иргэн тэтгэвэрт гарах нөхцөл бүрдэх бөгөөд сарын дундаж тэтгэврийг 284.7 мянган төгрөгөөр тооцож жил бүр 44.6 тэрбум төгрөг нэмж зарцуулж байна.

10/ Тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөх: Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1995-2019 онуудад төлж чадаагүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх хуулийг 2020 онд хэрэгжүүлж эхлээд байна. Уг хуулийн хүрээнд 17.5 мянган иргэн хамрагдан тэтгэврийн даатгалын санд 34.6 тэрбум төгрөг төвлөрүүлэн, сангаас нөхөн даатгалд хамрагдсан 6.5 мянган иргэнд 9.8 тэрбум төгрөг зарцуулсан.

11/ Эхчүүдийн ажилласан жилийг нэмэгдүүлж, даатгалгүй эхчүүдийн шимтгэлийн 50 хувийг 2020 оноос эхлэн төр хариуцах: 1/Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн НДШ төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарыг нэмж тооцох арга хэмжээний хүрээнд 22.9 мянган эхчүүдийн тэтгэвэрт 10.5 тэрбум төгрөг зарцуулсан. 2/Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийн жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг цалин хөлснийх нь 70 хувиар тооцож байсныг 100 хувиар тооцож олгох арга хэмжээнд 3.0 тэрбум төгрөг нэмж зарцуулсан. 3/ Нийгмийн даатгалд даатгуулаагүй эх хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг төрөөс төлөх арга хэмжээнд 8.0 мянган даатгуулагч эх хамрагдан улсын төсвөөс 1.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг хариуцан төлсөн. 4/ Сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас төлөх арга хэмжээнд 5.9 мянган эх хамрагдан тэтгэмжийн даатгалын сангаас 1.8 тэрбум төгрөгийг төлсөн байна.

12/ Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэрт гарсан зарим эхчүүдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх: 1990 оны тэтгэврийн хуулиар эрт тэтгэвэрт гарсан иргэдийн одоо авч байгаа сарын тэтгэврийн хэмжээг 2020 оноос эхлэн 50.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхэд 37.1 мянган тэтгэвэр авагчид 21.6 тэрбум төгрөг зарцуулсан.

13/ Агаарын бохирдлыг бууруулах: Гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, гэр хорооллын бүсийг шөнийн цахилгааны үнийн урамшуулалд хамруулах, агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот айл өрхөд цахилгаан халаагуур, сайжруулсан зуух, хагас боловсруулсан түлш олгох, халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг дулааны төвлөрсөн системд холбох, нярай хүүхдийг дархлаажуулалтын вакцинд хамруулах зэрэг арга хэмжээнд улс болон орон нутгийн төсвөөс 2018 онд 18.5 тэрбум төгрөг, 2019 онд 98.5 тэрбум төгрөг зарцуулсан бол 2020 онд 140.8 тэрбум төгрөг зарцуулсан бол 2021 онд 145.7 тэрбум төгрөг төсөвлөн хэрэгжүүлж байна.

14/ Элэг бүтэн Монгол хөтөлбөр: Элэгний С хепатитийн вирусийн халдвартай өвчтөнд дэлхийн жишигт хүрсэн тусламж, үйлчилгээг хүргэх замаар өвчний тархалтыг хязгаарлаж, өвчлөл, эндэгдэл бууруулахад зориулж 2016 оноос эхлэн жилд дунджаар 26.7 тэрбум төгрөг зарцуулж шинжилгээ, болон шаардагдах эмийн зардлыг 2020 он хүртэл санхүүжүүлсэн.

15/ “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” хөтөлбөр: Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2019 онд 4.7 тэрбум төгрөг зарцуулсан бол 2020 онд 6.2 тэрбум төгрөг зарцуулж байна.

16/ “Насны хишиг” хөтөлбөр: 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн ахмад настай азай буурлуудад насны хишиг олгох арга хэмжээнд жил бүр 21.7 тэрбум төгрөг зарцуулж байна

17/ **Засгийн газрын зарим тусгай санг шинээр байгуулах:** Эрүүл мэндийг дэмжих сан, Спортыг дэмжих сан, Соёл, урлагийг хөгжүүлэн санг 2018 онд байгуулж жил бүр 2.0 тэрбум төгрөг, Кино урлагийг хөгжүүлэх санг 2020 байгуулж 10.0 тэрбум төгрөг хуваарилаад байна.

18/ **МСҮТ-д суралцагчийн тэтгэлэг:** Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж байгаа суралцагчид 2019 онд сар бүр 100 мянган төгрөг олгоход 41.0 тэрбум төгрөг зарцуулсан бол 2020 оноос сар бүр 200 мянган төгрөгийн тэтгэлэг олгоход жилд 80.0 тэрбум төгрөг зарцуулахаар байна.

19/ **Орон нутгийн төсөв санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах:** Аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүр өөрийн “орон нутгийн хөгжлийн сан”-тай болж нийтдээ жилд дунджаар 100.0-200.0 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг иргэдийн оролцоотойгоор төлөвлөн санхүүжүүлж байна. Түүнчлэн, 2019 оноос эхлэн ашигт малтмалын хайгуулын лицензийн төлбөрийн 50 хувь, түүхийн нүүрсний агаарын бохирдлын төлбөрийн 50 хувь, газрын тосны лицензийн төлбөрийн 30 хувь болох нийт 33 тэрбум төгрөгийг орон нутагт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор орон нутгийн төсөвт шинээр хуваарилж байна.

20/ **Хүүхдийн хоолны зардал:** Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг 2020 оноос тус бүр 2 дахин нэмэгдүүлэхэд 57.1 тэрбум төгрөг нэмж зарцуулна.

21/ **Коронавируст халдвар цар тахал (Ковид-19)-ын эсрэг Засгийн газраас 2020 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.**

Өрх, иргэдэд чиглэсэн арга хэмжээ:

1/. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид ажиллаж байгаа 817,617 татвар төлөгч иргэдийг цалингаасаа төлдөг Хувь хүний орлогын албан татвараас 6 сарын хугацаанд чөлөөлсөн бөгөөд 198.9 тэрбум төгрөгийг,

2/. Үйл ажиллагаа нь зогссон 7284 аж ахуйн нэгжийн /давхардсан тоогоор/ 220849 даатгуулагч ажилтнуудад 3 сарын хугацаанд сар бүр 200.000 төгрөг олгох арга хэмжээнд 44.2 тэрбум төгрөгийг,

3/. Аж ахуйн нэгжид ажиллагч болон сайн дурын даатгуулагч 567135 даатгуулагчийн НДШ-ыг 6 сарын хугацаанд чөлөөлөх арга хэмжээнд 304.8 тэрбум төгрөгийг,

4/. Аж ахуйн нэгжид ажиллагч болон сайн дураар даатгуулагч 571597 даатгуулагчийн НДШ-ыг 3 сарын хугацаанд 5.0 хувь болгож хөнгөлөх арга хэмжээнд 50.8 тэрбум төгрөгийг,

5/. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлэх арга хэмжээнд 1.2 сая хүүхдэд 1060.4 тэрбум төгрөгийг,

6/. Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн 119,352 хүүхдэд олгох хүнсний талоны үнийг 16,000 төгрөгт хүргэж 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээнд 13.1 тэрбум төгрөгийг,

7/. Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн 123,935 насанд хүрэгчдэд олгох хүнсний талоны үнийг 32,000 төгрөгт хүргэж 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээнд 31.5 тэрбум төгрөгийг,

8/. Нийгмийн халамжийн тэтгэврийг 59,361 хүнд 100.000 төгрөгөөр нэмэгдүүлж 288.000 төгрөгт хүргэх арга хэмжээнд 122.9 тэрбум төгрөгийг,

9/. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны 11,052 хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 288.000 төгрөгт хүргэсэн ба уг арга хэмжээнд нийт 21.7 тэрбум төгрөгийг,

10/. 203,441 малчдад 1кг ноолуур тутамд 20.000 төгрөгийн урамшуулал олгох арга хэмжээнд 175.0 тэрбум төгрөгийг,

11/. ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрт зориулан нөөцөлсөн хүнсний бүтээгдэхүүнийг нийт 44 мянган хүүхэд, цэцэрлэгийн насны 18 мянга, сургуулийн насны 26 мянган хүүхдийг хамарсан зорилтод бүлгийн өрхүүдэд тараах арга хэмжээнд 3.7 тэрбум төгрөгийг,

12/. Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн 2021.07.01-ний өдөр хүртэлх хугацааны үндсэн болон хүүгийн төлбөрийг зээлдэгчийн хүсэлтэд үндэслэн хойшлуулах,

13/. Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос иргэдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хугацааг хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчийн хүсэлтэд үндэслэн хойшлуулах,

14/. Нийслэлийн гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний үнийг 50 хувиар хөнгөлөх,

15/. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор 203 аж ахуйн нэгж, 99 иргэний импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээнд 99 9.4 тэрбум төгрөгийг тус тус төлөвлөсөн.

Аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн арга хэмжээ

16/. Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой 105 аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогыг 6 сарын хугацаанд орлогын албан татвараас чөлөөлөх арга хэмжээнд 78.9 тэрбум төгрөгийг,

17/. Түрээсийн төлбөрөө бууруулсан 53 аж ахуйн нэгжид бууруулсан хэмжээгээр нь түрээсийн орлогод ногдох татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээнд 800 сая төгрөгийг,

18/. Татварыг ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийг нэг удаа чөлөөлөх арга хэмжээнд 356,233 татвар төлөгчид 48.2 тэрбум төгрөгийг,

19/. 6100 аж ахуйн нэгжийн НДШ-ийг ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийг нэг удаа чөлөөлөх арга хэмжээнд алданги 8.3 тэрбум төгрөг, торгууль 6.1 тэрбум төгрөг, нийт 14.4 тэрбум төгрөгийг,

20/. 38399 аж ахуйн нэгж байгууллагын төлөх НДШ-ийг 6 сарын хугацаанд чөлөөлөх арга хэмжээнд 262.1 тэрбум төгрөгийг, 3 сарын хугацаанд 5.0 хувь болгож хөнгөлөх арга хэмжээнд 46.9 тэрбум төгрөгийг,

21/. Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос аж ахуйн нэгжид олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хугацааг хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчийн хүсэлтэд үндэслэн хойшлуулах,

22/. 15.0 мянган тонн элит үрийн улаан буудай, дотоодын гурилын үйлдвэрлэлд шаардагдах 160.0 мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа, өндөг, элсэн чихэр, ургамлын тосыг гаалийн албан татвар, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх 112 аж ахуйн нэгжид олгох 24.3 тэрбум төгрөгийг,

23/. Өрх, аж ахуйн нэгжийн эрчим хүч, хог, усны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд төрөөс хариуцах арга хэмжээнд 92.8 тэрбум төгрөгийг,

24/. Бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос болон өвс, мал, амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж дотооддоо борлуулсан хүнсний будаа, ургамлын тос, өвс, мал, амьтны бүх төрлийн тэжээлийг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

1.3.3 Татвар, орлогын чиглэлээр баримталсан бодлого, томоохон бодлогын өөрчлөлт, түүний үр дүнгийн тухай

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, дотоодын үйлдвэрлэл, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих, ажилгүйдлийг бууруулах, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг нэвтрүүлэх, татварын үйл ажиллагааг хялбарчлах, цахимжуулах, ажил гүйлгээг бүртгэлжүүлэх, татварын хяналтын тогтолцоог сайжруулах, зэрэг татварын бодлогын томоохон өөрчлөлтүүдийг 2016-2020 оны хооронд хийсэн.

Татварын хяналтын тогтолцоог сайжруулах, татварын орлогыг бүрэн хураах, цахимжуулах, ажил гүйлгээг бүртгэлжүүлэх зорилгоор хийсэн томоохон өөрчлөлтөөс дурдвал:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаар 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр хэлэлцэн баталж, ашигт малтмал тусгай зөвшөөрөл болон газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч тус эрхээ хувьцаа борлуулах, шилжүүлэх замаар татвараас зайлсхийх явдлын эсрэг хууль, эрх зүйн орчныг сайжруулсан.
- Газрын тухай хуульд, Газрын төлбөрийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаар 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцэн баталж газрын бүртгэлийг цахимжуулж, төлбөр төлөх ажиллагааг хялбарчлан, газрын төлбөрийг бүрэн хураах чиглэлээр дэвшилт гаргасан.
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаар 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн баталж, ашигт малтмал экспортолсон этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй байх, Нүүрсний ангиллыг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний ангиллаас салгасан.

- Экспортын эрдэс баялаг, импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг цогцоор нь шийдвэрлэх замаар төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлж татварыг бүрэн хураах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах гаалийн шинэчлэлийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлсэн.

Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2006 онд батлагдсанаас хойш манай улсын эдийн засаг, санхүүгийн орчин эрс өөрчлөгдөж, олон улсын бизнесийн харилцаанд улам бүр татагдан орж, үндэстэн дамнасан компаниудын үйл ажиллагаа идэвхжиж татварын орчныг сайжруулах шаардлага үүсэж байсан.

Энэхүү шаардлагын хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулиудын төслийг боловсруулж Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр батлууллаа.

Татварын багц хуулиудын онцлох өөрчлөлтүүдийг дурдвал:

1. Татварын ерөнхий хууль:

- Татвар төлөгч сайн дурын үндсэн дээр тайлангаа засах, залруулах эрхтэй болсон;
- Татварын зорилгоор бусад улс оронтой мэдээлэл харилцан солилцох дотоодын эрх зүйн орчныг бүрдүүлэв;
- Татвар төлөхөөс зайлсхийх явдлын эсрэг авах арга хэмжээг шинээр хуульчилсан;
- Татварын тайлангийн алдааг урьдчилан илрүүлж, татвар төлөгчид туслах үйл ажиллагааг нарийвчлан журамласан;
- Үнэ шилжилтийн зарчмыг олон улсын стандартад нийцүүлж хуульчилсан;
- Татварын албаны хяналт шалгалтыг зөвхөн эрсдэлд үндэслэн хийх зарчмыг нэвтрүүлэв;
- Татварын өр төлөх хугацааг сунгасан;
- Маргаан таслах үйл ажиллагааг хялбарчилж, үе шатыг багасгав;
- Бизнес эрхлэгчийн тайланг хялбаршуулсан;
- Илүү төлсөн татварыг эхний ээлжид буцаан олгох боломжтой болсон.

2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль:

- Татварын хялбаршуулсан тогтолцоог нэвтрүүлсэн;
- Гадаад улсад төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасагдуулж тооцох зарчмыг тусгасан;
- Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох харилцааг шинэчилсэн;
- Зарим төрлийн татварын хувь хэмжээг бууруулсан.
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх харилцааг боловсронгуй болгосон.
- Жижиг, дунд аж ахуйн нэгжийн тайлангийн тоог цөөрүүлсэн.
- Барилга, байгууламжийн элэгдэл байгуулах хугацааг 25 жил болгож бууруулсан.

3. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль:

- Татварын хялбаршуулсан тогтолцоог нэвтрүүлсэн;

- Бичил худалдаа, ажил, үйлчилгээнээс орлого олж байгаа хувь хүний татварын харилцааг энгийн ойлгомжтой болгосон;
- Гадаад улсад төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох зарчмыг тусгасан;
- Байнга оршин суугч албан татвар төлөгчийн тодорхойлолтыг боловсронгуй болгосон;
- Татварын хувь хэмжээ хоорондоо уялдаагүй байсныг уялдуулж, хуулийн хэрэгжилтийг үр ашигтай болгосон;
- Татвар ногдох орлогын ангилал, тодорхойлолтуудыг боловсронгуй болгосон.
- Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэйгээр олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхой болгосон;
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх харилцааг боловсронгуй болгосон;
- Орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх хөнгөлөлтийг нэмэгдүүлсэн.

Түүнчлэн, татварын бааз суурийг хамгаалах, олон улсын стандартуудыг нэвтрүүлэх, үндэстэн дамнасан корпорацуудын татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээг авах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ:

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын зорилго бүхий мэдээлэл солилцоо, ил тод байдлын олон улсын форумд Монгол Улс 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гишүүнээр элсэн орсон.
- Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг олон улсын үйл ажиллагаанд 2018 онд гишүүнээр элсэн орсон.
- Татварын зорилгоор захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцыг 2020 оны 1 дүгээр сарын 3-нд Улсын Их хурлаар хэлэлцэн баталж, дэлхийн 150 гаруй улс оронтой мэдээлэл харилцан солилцох эрх зүйн орчин бүрдсэн.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор дараах багц арга хэмжээг хэрэгжүүллээ:

- 2020 оны 4 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд хувийн хэвшлийн ААН-д ажиллаж байгаа иргэдийг цалингаасаа төлдөг Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлсөн;
- 2020 оны 2 дугаар сарын 1-нээс 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд Коронавируст халдвар / КОВИД -19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө;
- 2020 оны 4 дүгээр сарын 1-нээс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогыг албан татвараас чөлөөлсөн;
- 2020 оны 2 дугаар сарын 1-нээс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд түрээсийн төлбөрийг бууруулсан татвар төлөгчид татварын хөнгөлөлт эдлүүлнэ;

- 2020 оны 2 дугаар сарын 1-нээс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд татварыг ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийг нэг удаа чөлөөлнө;
- Дотоодын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилгоор 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд 15.0 мянган тонн элит үрийн улаан буудай, дотоодын гурилын үйлдвэрлэлд шаардагдах 160.0 мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тосыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн;
- Дотоодын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилгоор 2021 оны 7 дугаар сарын 1-нийг хүртэл хугацаанд бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос болон өвс, мал, амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж дотооддоо борлуулсан хүнсний будаа, ургамлын тос, өвс, мал, амьтны бүх төрлийн тэжээлийг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлнө.

1.3.4 Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, томоохон бодлогын өөрчлөлт, түүний үр дүнгийн тухай


Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 2016 онд 1047.3 тэрбум төгрөг, 2017 онд 779.3 тэрбум төгрөг, 2018 онд 766.2 тэрбум төгрөг, 2019 онд 1698.3 тэрбум төгрөгөөр тус тус батлагдсан. Дөрвөн жилийн хугацаанд нийт 4,291.1 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ батлагдан хэрэгжсэнээс 2016-2019 онд нийт 3,911.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан нь Монгол Улсын түүхэнд 4 жилийн хугацаанд хийгдсэн хамгийн өндөр үзүүлэлт юм.

Бүтээн байгуулалтын хувьд 2016-2019 оны хооронд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 147 цэцэрлэг, 100 сургууль, 30 дотуур байр, 52 эмнэлэг, 1404.6 км авто зам ашиглалтад орсон байна.

2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 1,654.3 тэрбум төгрөг батлагдсанаас 1356 төсөл, ага хэмжээг хэрэгжүүлэхэд 1,414.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Шилжих 503 төслийн 2020 онд санхүүжих 778.6 тэрбум төгрөгөөс 655.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлж гүйцэтгэл 84.2%, 2020 онд шинээр хэрэгжиж эхэлсэн 844 төслийн 2020 онд санхүүжих 552.3 тэрбум төгрөгөөс 437.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлж гүйцэтгэл 79.3%-тай гарсан.

Зураг 37. Улсын төсвийн хөрөнгийн зардал /тэрбум төгрөгөөр/




Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд нийт 3,763.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,390.9 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1100 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан, мөн өмнөх онуудад концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн гэрээний эргэн төлөлтөд 5 төслийн 266.3 тэрбум төгрөг, нийт 1,657.2 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 24 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад нийт 1,390.9 тэрбум төгрөг батлагдсанаас 26% нь боловсрол, шинжлэх ухааны салбарт, 16.9% нь зам тээврийн салбарт, 13.4% нь барилга, хот байгуулалтын салбарт, 7.4% нь соёлын салбарт, 5.8% нь эрүүл мэндийн салбарт хэрэгжих бол үлдсэн хувь нь бусад салбарт хэрэгжинэ.

Улсын хэмжээнд 2021 онд 111 цэцэрлэг, 103 сургууль, 67 авто замын төсөл, 58 эмнэлэг, 38 инженерийн шугам сүлжээ, 37 соёлын төв, 26 спорт заал, тохижилт, гэрэлтүүлгийн 26 төсөл, 25 дотуур байр, 15 гүүрний байгууламж, 13 спорт цогцолбор, 13 сургууль, цэцэрлэгийн цогцолбор, аялал жуулчлалын 12 төсөл хэрэгжих бол бусад чиглэлийн 230 төсөлд хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтыг барилга байгууламж, их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн төрлөөр доорх графикт харуулав.

Зураг 38. Улсын төсвийн хөрөнгийн зардал /төрлөөр/



● БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Дэд бүтэц болон төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, төр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламжийн төслүүдэд нийт **1,112.3** тэрбум төгрөг.

● ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Шинээр ашиглалтад орж байгаа нийгмийн салбарын төслүүд болон төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмжийн зардалд **153.7** тэрбум төгрөг.

● ИХ ЗАСВАР, ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨВ

Барилга байгууламжийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх зориулалт бүхий их засвар болон төсвийн ХО-р хэрэгжүүлэх төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах зардалд **124.9** тэрбум төгрөг.

2016-2021 оны хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын гол бодлого, өөрчлөлт, түүний үр дүнгийн талаар авч үзвэл:

Монгол Улсын 2016 оны төсөв

- Монгол Улс 2012-2016 оны хооронд хөрөнгө оруулалтын хувьд төсвөөс гадуур хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжилтийг хийж байсан бөгөөд үүнийг 2016 оны сүүлээс 2017 оны хооронд таслан зогсоож, төсвөөс гадуурх бүх санхүүжилтийг төсөвт нэгтгэж, төсвийн сахилга батыг сайжруулсан. Тухайлбал, улсын төсөвт тусгагдан, хэрэгжсэн боловч 2013-2015 онуудад санхүүжилтээ авч чадаагүй ажлуудын санхүүжилтийг Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр векселиэр төлбөрийг баталгаажуулсан байдаг.
- Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 108 дугаар тогтоолын дагуу төсвийн тухай хуульд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжүүлж чадаагүй үлдэгдлийг 2015-2016 онуудад векселиэр санхүүжүүлсэн. Дээрх УИХ-ын тогтоолын дагуу 2015-2016 онд векселиэр төлбөр баталгаажуулсан төсөл, арга хэмжээний үндсэн төлбөрийг хүүгийн хамт нийт 672,929.5 сая төгрөгийг 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар УИХ-аас баталж, векселийн төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.
- УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 47 дугаар тогтоолоор улсын төсөв болон Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжүүлж чадаагүй үлдэгдэл, "Барих-шилжүүлэх" концессын гэрээний эргэн төлөлт, шүүхийн шийдвэрээр олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн векселиэр баталгаажуулахгүй байхаар зааж, дахин Вексель бичих үйл ажиллагааг бүрэн зогсоосон.

Монгол Улсын 2017 оны төсөв

- Хөрөнгө оруулалттай холбоотой 2017 онд хэрэгжүүлсэн нэг том алхам бол 2015-2017 онуудад Хөгжлийн банкны санхүүжилтээр Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлж байсан төслүүдийн санхүүжилтийг зогсоож, Хөгжлийн банкны тухай

хуулийн шинэчилсэн найруулга, Улсын Их Хурлын 2016 оны "Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай" 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016 оны "Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай" 219 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны "Өрийн зохицуулалт хийх арга хэмжээний тухай" 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хөгжлийн банк, Сангийн яамны хооронд нийт өглөг, авлагыг 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгаж, тооцоо нийлж хаасан.

- Концессын “Барих-Шилжүүлэх” гэрээ шинээр байгуулахгүй байх УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоол шийдвэр гарч, хэрэгжиж дууссан “Барих-Шилжүүлэх” концессын төслүүдийн санхүүжилтийг хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтэд үндэслэн олгож байхаар заасан.

Монгол Улсын 2018 оны төсөв

- “Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй болгох”, “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, анги дүүргэлт хэт өндөр сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид бүрэн шилжүүлэх, төв цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх, Улаанбаатар хотын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах бодлогыг 2018 онд баримталсан.
- ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах бодлогын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх аргачлал”-ыг 2018 онд батлуулан ашиглаж эхлээд байна. Үүний үр дүнд нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, оновчтой, үр ашиг бүхий төслүүд хэрэгжих боломж бүрдсэн.

Монгол Улсын 2019 оны төсөв

- Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулж, ил тод байдлыг хангах зорилгоор “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-ийг боловсруулан, “publicinvestment.gov.mn” цахим хуудас болон “төсвийн хөрөнгө оруулалт” гар утасны аппликейшныг ажиллуулж эхэлсэн. Анх удаа 2020 оны төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төслүүдийг цахим аргачлалын дагуу боловсруулж, цахим системээр хүлээн авч ажилласан. Аргачлалыг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч бүхий л байгууллагууд цахим системээр дамжуулан ашиглаж үе шаттай төлөвлөж, хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлж байна. Аргачлалын дагуу хөрөнгө оруулалтыг төлөвлөснөөр:
 - Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн бодит эрэлт, хэрэгцээг тодорхойлох;
 - Төслийг хэрэгжүүлэх боломжит хувилбарыг сонгох;
 - Тухайн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн болон урсгал зэрэг нийт зардлыг тооцоолох;
 - Олон шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлэх;
- Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдох бүхий төслүүдийг сонгож төсвийн төсөлд тусгах боломж бүрдсэн.
- 2019 онд төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ажлын 1-3 хоногт багтаан түргэн шуурхай шийдвэрлэдэг болсон. Ингэснээр 46 сургууль, 76 цэцэрлэг, 12 дотуур байр, 30 эмнэлэг, 42 соёл, спортын цогцолбор, номын сан, 74 дэд бүтэц, инженерийн байгууламжууд ашиглалтад орлоо.

Монгол Улсын 2020 оны төсөв

- Он дамжин хэрэгжиж шилжих төслүүдийн санхүүжилтийг хуулийн дагуу 2020 онд бүрэн санхүүжүүлэх, шинэ төрлийн КОВИД-19 вирусийн тархалттай холбоотойгоор эрүүл

мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх бодлого баримталсан.

- Ажил нь зогсож удааширсан, царцаагдсан төслүүдээс 2018-2019 онд нийт 28.8 тэрбум төгрөгийн 41 төсөл, арга хэмжээг төсөвт тусгаж шийдвэрлэсэн бол 2020 оны төсвийн төсөлд 23 царцаагдсан төслийг бүрэн дуусгахад шаардлагатай 22.8 тэрбум төгрөгийг тусгасан. Мөн гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, байгалийн баялгаас татварыг бүрэн хураах боломжийг бүрдүүлэх “Гаалийн шинэчлэл” төсөл, арга хэмжээний хүрээнд гаалийн боомтын шинэчлэл хийгдэж, зорчигч тээвэр, ачаа тээврийн барилга байгууламж, иж бүрэн шугам сүлжээ, дэд бүтэц, зам талбай, ногоон байгууламжийн цогцолборууд баригдсан.
- Түүнчлэн КОВИД-19 вирусийн эсрэг хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн эмнэлгүүдийг ашиглалтад оруулах, яаралтай түргэн тусламж, мэс засал, оношилгооны болон шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг нэн тэргүүн ээлжид санхүүжүүлж ажилласан.

Монгол Улсын 2021 оны төсөв

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг төсвийн төсөлд тусгахдаа дараах зарчим, бодлогыг баримталж ажилласан. Үүнд:

- Өмнөх онуудад эхлүүлсэн үргэлжилж байгаа төслүүдийн санхүүжилтийг тусгах,
- Нийгмийн шаардлага өндөр сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгыг үргэлжлүүлэн дуусгах,
- Орон нутаг, салбаруудад тулгамдсан асуудлыг шийдвэрлэх,
- Аймаг, нийслэл, ТЕЗ, УИХ-ын гишүүдээс ирүүлсэн саналуудын уялдааг хангаж төлөвлөх,
- Саарал жагсаалтаас гарах зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууль хүчин, батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалтыг тусгах.

Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийн тухай

Анх удаа 2016 онд Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн төслийн эргэн төлөлтийг улсын төсөвт тусган санхүүжүүлсэн бөгөөд үнээс хойш жил бүр эргэн төлөлтийн хэмжээ нэмэгдсэн.

Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр нийтдээ 2,016.2 тэрбум төгрөгийн гэрээ бүхий 37 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд улсын төсвөөс санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн бөгөөд 25 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг бүрэн олгож дууссан. Концессын төслүүдийн эргэн төлөлтөд 2016-2020 онд нийтдээ 784.1 тэрбум төгрөгийг олгоод байна. Улсын Их Хурлаас батлагдсан 2021 оны төсвийн тухай хуульд 5 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 266.3 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд үүнээс 2 төслийн эргэн төлөлтийг бүрэн олгож дуусгана. 2021 оны төсөвт тусгагдсан 3 төслийн эргэн төлөлтийг дараагийн жилүүдэд үргэлжлүүлэн олгоно. Одоогийн байдлаар хэрэгжүүлж байгаа 7 төслийн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг дараа жилүүдийн улсын төсөвт ажлын бодит гүйцэтгэл, Үндэсний аудитын газрын дүгнэлтийг үндэслэн тусгах юм.

Цаашид улсын төсвөөс 2022-2025 онд нийтдээ 962.8 тэрбум төгрөг шаардагдахаар байгаагаас 2022 оны улсын төсөвт 2021 онд улсын төсөвт тусгагдсан төсөл, арга хэмжээний гэрээний үлдэгдэл санхүүжилт болох 485.7 тэрбум төгрөгийг тусгахаар байна. Үлдэгдэл 477.0

тэрбум төгрөгийг 2022-2025 оны улсын төсөвт тусгахаар тооцоо гарч байгаа нь төсөвт томоохон дарамт учруулахаар байна.

Иймд төр хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаанд шинэчлэлт хийх зайлшгүй шаардлага үүссэн байгаа бөгөөд төсвийн тооцоо судалгаа, төсөвт үзүүлэх эрсдэл зэргийг тооцох замаар төсөвтэй нягт уялдуулах хэрэгтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутаг, гадаад зээл тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бодлогыг нэг цонхоор төлөвлөх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчинг сайжруулах,
- Төсвөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төслүүдийн үр дүн, үр ашгийг тооцдог болох,
- Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлж, хэрэгжилтийг сайжруулах тогтолцоог улам бүр боловсронгуй болгож, төсвийн хөрөнгө оруулалтын ил тод байдлыг хангах зорилго бүхий “publicinvestment.gov.mn” цахим систем болон “төсвийн хөрөнгө оруулалт” гар утасны апп-ны хөгжүүлэлтийг үргэлжлүүлэн хийх.

1.4 Төсвийн тусгай шаардлага

1.4.1 Төсвийн орлогын тусгай шаардлага

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх” гэж заасны дагуу 2016-2020 оны төсвийн орлогын тэнцвэржүүлсэн журмаар тооцож ирсэн. Ингэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.2-т заасны дагуу тухайн жилийн гол нэр төрлийн эрдэс баялгийг тодорхойлж, 11.1.3.а-д заасны дагуу тэнцвэржүүлсэн үнийг тооцоолсон. Дараах хүснэгтээр 2016-2020 оны төсвийн гол нэр төрлийн эрдэс баялаг, түүний тэнцвэржүүлсэн үнэ, зах зээлийн үнэ болон тэнцвэржүүлсэн орлогын мэдээллийг үзүүллээ.

Хүснэгт 13. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, 2016-2020 он

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гол нэр төрлийн эрдэс баялаг	
		Зэс	Нүүрс
2016 он гүйцэтгэл			
Тэнцвэржүүлсэн үнэ	<i>\$/мн</i>	5,137.7	-
Зах зээлийн үнэ	<i>\$/мн</i>	4,862.8	15.2-77.2
Тэнцвэржүүлсэн орлого	<i>Тэрбум төгрөг</i>	5,835.0	
2017 он гүйцэтгэл			
Тэнцвэржүүлсэн үнэ	<i>\$/мн</i>	4,599.4	-
Зах зээлийн үнэ	<i>\$/мн</i>	6,162.3	26.9-140.6
Тэнцвэржүүлсэн орлого	<i>Тэрбум төгрөг</i>	7,274.8	
2018 он гүйцэтгэл			
Тэнцвэржүүлсэн үнэ	<i>\$/мн</i>	5,106.9	75.98
Зах зээлийн үнэ	<i>\$/мн</i>	6,524.8	32.6-137.3
Тэнцвэржүүлсэн орлого	<i>Тэрбум төгрөг</i>	9,345.1	
2019 он гүйцэтгэл			
Тэнцвэржүүлсэн үнэ	<i>\$/мн</i>	6,222.2	75.5
Зах зээлийн үнэ	<i>\$/мн</i>	6,004.6	31.0-131.7
Тэнцвэржүүлсэн орлого	<i>Тэрбум төгрөг</i>	10,905.5	
2020 он урьдчилсан гүйцэтгэл			
Тэнцвэржүүлсэн үнэ	<i>\$/мн</i>	6,290.5	75.5
Зах зээлийн үнэ	<i>\$/мн</i>	6,168.5	32.0-125.0
Тэнцвэржүүлсэн орлого	<i>Тэрбум төгрөг</i>	9,421.6	
2021 оны төлөвлөгөө			
Тэнцвэржүүлсэн үнэ	<i>\$/мн</i>	5,343.4	74.1
Зах зээлийн үнэ	<i>\$/мн</i>	6,500.0	28.0-103.0
Тэнцвэржүүлсэн орлого	<i>Тэрбум төгрөг</i>	11,797.8	

1.4.2 Төсвийн тэнцлийн тусгай шаардлага

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг 2013 оны төсвийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс ОУВС-тай хамтран 3 жилийн хугацаатай “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлж нэн тэргүүнд төсвийн нэгдмэл байдлыг бодитойгоор хангах, сахилга батыг чангатгах, төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох, төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах замаар дунд болон урт хугацаанд төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулахаар зорилт тавин ажилласан. Энэ хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот түвшнийг 2017-2023 он хүртэл дахин тодорхойлох зайлшгүй шаардлага үүссэний дагуу тус хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулан “Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.” гэж тусгасан 19.9 дахь заалтыг нэмсэн.

Хүснэгт 14. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /ДНБ-д эзлэх хувь/

	2016	2017	2018	2019	2020*	2021	2022	2023
1 Хуулиар тогтоосон хязгаар	-18.5%	-10.4%	-9.5%	-6.9%	-5.1%	-5.1%	-3.6%	-2.8%
2 Батлагдсан	-18.0%	-9.5%	-8.0%	-5.4%	-12.5%	-5.1%	-3.6%	-2.8%
3 Гүйцэтгэл	-15.3%	-6.4%	0.1%	-2.0%				

*Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8.1-д заасны дагуу 2020 онд энэ тусгай шаардлагыг түр түдгэлзүүлсэн.

1.4.3 Зарлагын өсөлтийн тусгай шаардлага

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3 дугаар зүйлд заасан тусгай шаардлагын тооцоолол, тайлбар

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3 зүйлд заасан тусгай шаардлагад “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээх хэтрэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж байна.

2016 он. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 2016 онд 2,357.4 тэрбум төгрөг буюу өмнөх жилийнхээс 33.0 хувиар өссөн нь 2016 оны батлагдсан төсөвт тодотгол хийж зардлыг нэмсэнтэй холбоотой юм. Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувиас 14.7 нэгжээр, 2016 оноос өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн дунджаас 21.9 нэгжээр тус тус доогуур байсан нь төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байв.

2017 он. 2017 оны хувьд нэгдсэн төсвийн нийт зарлага 478.0 тэрбум төгрөг буюу өмнөх жилийнхээс 5.0 хувиар буурсан байна. Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувиас 9.0 нэгжээр доогуур, харин 2017 оноос өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний

өсөлтийн дунджаас 21.8 нэгжээр доогуур гарсан байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тодорхой хоёр хэлбэрийн ДНБ-ний өсөлтийн аль ихээс хэтрэхгүй байхаар заасан тул төсвийн тусгай шаардлагыг хангасан байна.

2018 он. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого анх удаагаа 10 их наядыг давж, 2018 онд 10,172.8 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь 2010 оноос хойш анх удаа юм. Монгол Улсын эдийн засаг 2018 онд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хамгийн өндөр буюу 7.2 хувьд хүрлээ. Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувиас 6.7 нэгжээр доогуур, харин 2018 оноос өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн дунджаас 15.6 нэгжээр доогуур гарч зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангасан байна.

2019 он. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого анх удаа 2019 онд 12 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 94.6 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 1,040.2 тэрбум төгрөгийг хуваарилж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 10,905.5 тэрбум төгрөг болсон. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 11,661.7 тэрбум байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүн² - ий -2.0 хувьтай тэнцэж байна.

Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувиас 3.5 нэгжээр доогуур, харин 2019 оноос өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн дунджаас 3.1 нэгжээр доогуур гарч зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангасан байна.

2020 он. УИХ-аас баталсан Монгол Улсын 2020 оны төсөв, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсөв, Орон нутгийн 2020 оны төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн нийт зарлага нь 2019 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлээс 2,299.1 тэрбум төгрөгөөр буюу 19.7 хувиар нэмэгдэхээр байна. Энэ нь 2020 онд тооцоолсон эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувиас 2.7 нэгжээр дээгүүр, харин 2020 оноос өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн дунджаас 12.7 нэгжээр доогуур байхаар төлөвлөгдсөн буюу төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

2021 он. Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 8.5 хувьтай, 2009-2020 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 17.4 хувьтай тус тус тэнцэж байна. 2021 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт -4.3 хувь буюу тусгай шаардлагыг хангаж байна.

БҮЛЭГ ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ, НӨХЦӨЛ, ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨӨГҮЙ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ӨР БА ХҮҮГИЙН ТӨЛБӨРИЙН ДҮН

2.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ЗОРИЛТ


Монгол Улсын Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т заасан дараах үндсэн 5 зорилтын хүрээнд дунд хугацааны өрийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

- 1. Өрийн зохицуулалтын арга хэмжээг авна.** Засгийн газрын зүгээс арилжааны нөхцөлтэй 2020-2024 онуудад төлөгдөх 2.9 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасыг зах зээлийн тохиромжтой нөхцөлд төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр хугацаанаас нь өмнө төлж барагдуулах боломжийг эрэлхийлнэ.
- 2. Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлнэ.** Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.
- 3. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг боловсронгуй болгоно.** Засгийн газрын зүгээс цөөн тооны хөрөнгө оруулагчдад олон нийтэд хүртээмжтэй бусаар арилжаалж байсан Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны системийг боловсронгуй болгон олон нийтэд ил тод, нээлттэй хөгжүүлж дунд хугацаанд үнэт цаасны арилжааг тогтмолжуулах бодлогыг баримтална.
- 4. Болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулна.** Засгийн газрын зүгээс баталгаанаас үүсэх болзошгүй өр төлбөрийг багасгах, Засгийн газрын өрийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг бууруулах зорилгын хүрээнд өрийн баталгаа нэмж гаргахгүй бөгөөд үүссэн баталгаанд тавих хяналтыг сайжруулна.
- 5. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад би тэр зарим саналыг нь нийцүүлнэ.** Олон улсын санхүүгийн байгууллагууд хамтран Засгийн газрын өрийн удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээг хийдэг бөгөөд Монгол Улсын зүгээс 2008-2016 онд хангалтгүй үнэлэгдэж ирсэн. Сангийн яамны зүгээс өрийн удирдлагын тогтолцооны болон үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөөний дагуу шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэн, өрийн удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах бодлогыг баримталж байна.

Засгийн газрын зүгээс төсөв санхүү, мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлагыг тууштай хэрэгжүүлэх замаар өрийн тогтвортой байдлыг бүрдүүлж, дунд хугацаанд өрийн үйлчилгээний зардлыг бууруулах, төсөвт учруулах ачааллыг жигдлэх бодлогыг барьж байна. Үүний хүрээнд өндөр хүүтэй богино хугацаатай дотоод үнэт цаас гаргалтыг 2017 оны 10 дугаар сараас хойш зогсоож, хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах, барих-шилжүүлэх концесс, Засгийн газрын өрийн баталгаа зэрэг болзошгүй өр, төлбөрийн гэрээг шинээр байгуулахыг зогсоох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд зөвхөн хүү багатай гадаад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөлд түлхүү ашиглаж байна.

Засгийн газрын өрийн хүүгийн зардал 2017 онд 1,156 тэрбум төгрөг буюу төсвийн зарлагын 12.8 хувьтай тэнцэж байсан бол 2021 оны батлагдсан төсвийн хүрээнд 1,137.6 тэрбум төгрөг буюу төсвийн зарлагын 8.2 хувьтай тэнцэхээр байна.

Зураг 39. Засгийн газрын өрийн үйлчилгээ /тэрбум төгрөг/




Стратегийн баримт бичигт тусгасан дээрх зорилтуудыг хангаснаар дунд хугацаанд хүрэхээр төлөвлөсөн өрийн багцын зорилтот түвшин дараах байдалтай байна.

Хүснэгт 15. Өрийн багцын үзүүлэлтүүд

	2019	2020	2021	2022	2023
Жигнэсэн дундаж хүү	4.2	4.1	3.6	3.5	3.6
Эргэж төлөгдөх дундаж хугацаа	8.6	8.1	8.4	8.6	8.7
Хүү шинэчлэгдэх дундаж хугацаа	7.4	7.6	7.9	8.0	8.2
Гадаад валютаар илэрхийлсэн өр	94%	94%	93%	92%	92%

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг тухайн жилийн нэрлэсэн ДНБ-д харьцуулсан харьцаа 2021 онд 65.4 хувь, 2022 онд 59.7 хувь, 2023 онд 56.4 хувьд тус тус хүрэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

Зураг 40. Төсвийн тусгай шаардлагын төсөөлөл



2.1.1. Засгийн газрын өрийн өнөөгийн байдал

Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцааг 2016 оны төсвийн жилд 88.0 хувиас, 2017 оны төсвийн жилд 85.0 хувиас, 2018 оны төсвийн жилд 80.0 хувиас, 2019 оны төсвийн жилд 75.0 хувиас, 2020 оны төсвийн жилд 70.0 хувиас, 2021 оны төсвийн жилд 70.0 хувиас, 2022 оны төсвийн жилээс эхлэн 60.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан.

Засгийн газрын өрийн нэрлэсэн хэмжээ 2017 онд 22.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 72.5 хувьд хүрээд байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 27.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 62.3 хувьд хүрэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 16: Засгийн газрын өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2017.12.31	2018.12.31	2019.12.31	2020.12.31
I. Засгийн газрын дотоод өр	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6
1.1 Үнэт цаас	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6
II. Засгийн газрын гадаад өр	16,857.8	18,865.6	20,728.1	24,848.1

2.1	Үнэт цаас	7,701.6	7,664.5	7,927.2	8,354.0
2.2	Зээл	9,156.2	11,201.1	12,800.9	16,494.1
III. Засгийн газрын өрийн баталгаа		1,663.7	1,130.7	1,076.3	1,060.4
IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс		768.2	806.0	995.7	850.2
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР		22,751.6	22,367.0	24,199.7	27,895.4
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		20,212.1	18,955.9	20,525.6	23,024.3
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		85.0%	80.0%	75.0%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		72.5%	58.9%	55.6%	62.3%

Засгийн газрын зүгээс 2017 оноос эхлэн өндөр хүүтэй, богино хугацаатай дотоод үнэт цаас гаргалтыг бууруулж, санхүүжилтийн хэрэгцээг арилжааны нөхцөлтэй гадаад болон дотоод зээллэгээр санхүүжүүлэхгүй байх бодлогыг баримталсан.


2.1.2. Засгийн газрын дотоод үнэт цаас

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2017 онд 3,461.9 тэрбум төгрөг байсан бөгөөд тухайн онд Засгийн газар төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж 3,376.6 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан.

Засгийн газрын дотоод үнэт цаасны эргэн төлөлт нь төрийн сангийн мөнгөн хөрөнгөд дарамт учруулж, хүүгийн түвшин өндөр байсантай холбогдуулан Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг 2017 оны 10 дугаар сараас эхлэн зогсоож, зах зээлийн бодит хүүтэй харьцуулахад өндөр хүүтэй үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдан авсан.

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,136.6 тэрбум төгрөгт хүрч, 2017 оноос 67.2 хувиар буураад байна.


Сураг 41. Засгийн газрын дотоод үнэт цаас /жилээр, тэрбум төгрөг/



2.1.3. Өрийн бичиг

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 2015-2016 онд нийт 697.2 тэрбум төгрөгийн өрийн бичгийг бичиж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд олгосон. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үлдэгдэл, концессын эргэн төлөлтийг өрийн бичгээр баталгаажуулахыг хориглосноор 2016 оноос хойш шинээр өрийн бичиг бичигдээгүй бөгөөд 2016-2017 онд дээрх өрийн бичгийг мөнгөжүүлснээр Засгийн газрын өрд өрийн бичгийн үлдэгдэлгүй болсон.

Зураг 42: Өрийн бичиг/ вексель/-ийн үлдэгдэл



2.1.4. Гадаад үнэт цаас /бонд/

Монгол Улсын Засгийн газраас олон улсын санхүүгийн зах зээлд анх 2012 онд 1.5 тэрбум ам.долларын “Чингис” бондыг арилжаалсан бол 2015 онд 161.2 сая ам.долларын “ДимСам” бонд, 2016 онд 500.0 сая ам.долларын “Мазаалай” бонд, 2017 онд 600.0 сая ам.долларын “Хуралдай” бонд, 2018 онд 800.0 сая ам.долларын “Гэрэгэ” бонд, 2020 онд 600.0 сая ам.долларын “Номад” бондыг арилжаалж, нийт 6 удаагийн арилжаагаар 4,161.2 сая ам.долларын бондыг гаргасан. Үүнээс “Чингис”, “ДимСам”, “Мазаалай” бондуудыг төсөл, хөтөлбөр болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан бол “Хуралдай”, “Гэрэгэ”, “Номад” бондуудыг өмнөх гадаад бондуудын төлбөрийг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргасан.

Тухайлбал, Засгийн газар 2017 оны 03 дугаар сард төлөгдөх нөхцөлтэй байсан Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжүүлэхээр 2017 оны 3 дугаар сард “Хуралдай” бонд, 2018 онд төлөгдөх нөхцөлтэй байсан “Чингис”, “ДимСам” бондуудыг дахин санхүүжүүлэх зорилгоор 2017 оны 10 дугаар сард “Гэрэгэ” бондыг тус тус арилжаалж өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн Зорилт 1 -т 2021-2024 онд төлөгдөх нийт 2,900.0 сая ам.долларын гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлж, өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасны дагуу 2021 онд төлөгдөх Мазаалай бонд, 2022 онд төлөгдөх Чингис бондуудын төлбөрийн тодорхой хэсгийг

дахин санхүүжүүлэх зорилгоор 2020 оны 9 дүгээр сард 5.125 хувийн хүүтэй, 600.0 сая ам.долларын Номад бондыг гаргаж дахин санхүүжүүлсэн.

Дэлхий даяар тархаад буй Ковид-19 цар тахлын нөлөө Монгол Улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж буй энэ цаг үед 10.875 хувийн хүүтэй Мазаалай бондыг 5.125 хувийн бага хүүтэй шинэ бондоор сольсноор Засгийн газрын гадаад бондын хүүгийн зардлаас 26.7 сая ам.долларыг хэмнэх боломжтой болсон.

Ийнхүү өрийн дахин санхүүжилтийн арга хэмжээ авах нь 2021-2022 онуудад эргэн төлөгдөх нийт 1.5 тэрбум ам.долларын төлбөрийн дарамтыг бууруулж, эргэн төлөлтийн хугацааг 5.5 жилээр хойшлуулснаар Монгол Улсын макро эдийн засаг, төсөв, санхүүгийн нөхцөл байдал болон төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөц, гадаад ханшид үзүүлэх ачааллуудыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Засгийн шинээр гаргасан Номад бондыг олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжаалахад J.P.Morgan, Morgan Stanley, HSBC болон Nomura гэсэн 4 хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран ажилласан болно.

Хүснэгт 17. Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл

№	Үнэт цаасны нэр	Дүн сая\$	Гаргасан огноо	Купон /хувь/	Хугацаа	Үлдэгдэл 2020.12.31	
						сая \$	тэрбум ₮
1	"Чингис"	1000\$	2012/12/05	5.125%	10	799.2	2,277.3
2	"Мазаалай"	500\$	2016/04/06	10.875%	5	132.6	377.7
3	"Хуралдай"	600\$	2017/03/09	8.750%	7	600.0	1,709.7
4	"Гэрэгэ"	800\$	2017/10/26	5.625%	5.5	800.0	2,279.6
5	"Номад"	600\$	2020/10/07	5.125%	5.5	600.0	1,709.7
НИЙТ						2,931.7	8,354.0

2.1.5. Гадаад зээл

Монгол Улсын Засгийн газар 2017-2020 онд олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас төслийн зээлийн хүрээнд 1,905.3 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 1,406.2 сая ам.доллар, нийт 3,311.5 сая ам.доллар буюу 8,726.5 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийг авч ашигласан. Засгийн газрын зүгээс арилжааны нөхцөлтэй гадаад зээлээр төсвийн алдагдал санхүүжүүлэхгүй, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байх бодлогыг баримталж байгаа бөгөөд 2017-2020 онд арилжааны нөхцөлтэй зээл шинээр авч ашиглаагүй байна.

Хүснэгт 18. Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт

Төрөл	2017 он		2018 он		2019 он		2020 он		Нийт		
	USD	MNT	USD	MNT	USD	MNT	USD	MNT	USD	MNT	хувь
Төслийн зээл	309.7	752.1	404.0	1,015.6	457.8	1,229.1	733.8	2,076.8	1,905.3	5,073.6	58%
Хөтөлбөрийн зээл	606.0	1,478.1	190.0	474.9	150.5	409.5	459.7	1,290.3	1,406.2	3,652.8	42%
Нийт	915.7	2,230.2	594.0	1,490.5	608.3	1,638.6	1,193.5	3,367.2	3,311.5	8,726.5	100%

Эдийн засагт төсвийн болон төлбөрийн тэнцлийн хосолсон хүндрэл тулгарсантай холбогдуулан 2017 онд Засгийн газар ОУВС-тай хамтран Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг эхлүүлэн, гурван жилийн хугацаанд эдийн засгийг тогтворжуулж, сэргээх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавьж, төсвийн нэгдмэл байдлыг хангах, төсвийн сахилга батыг чангатгах, төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах замаар дунд болон урт хугацаанд төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах, төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлсэн.

1991 оноос хойш Монгол Улсад хөгжлийн албан ёсны тусламж хэлбэрээр томоохон зээлдүүлэгчдэд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, түнш орнуудад Япон Улс, БНХАУ зэрэг улс орнууд орж байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 16,494.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Япон улс болон БНХАУ зэрэг 4 зээлдүүлэгчид нийт 84.8 хувь буюу 13,980.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 19. Засгийн газрын гадаад зээлийн 2020 оны үлдэгдэл, зээлдүүлэгчээр

№	Зээлдүүлэгч	Дүн (тэрбум ₮)	Эзлэх хувь
1	Азийн хөгжлийн банк	4,937.8	29.9%
2	Япон улс	4,062.3	24.6%
3	Бүгд найрамдах Хятад ард улс	2,813.9	17.1%
4	Дэлхийн банк	2,166.5	13.1%
5	Бүгд найрамдах Солонгос улс	466.8	2.8%
6	Холбооны бүгд найрамдах Герман улс	315.0	1.9%
7	Олон улсын валютын сан	283.6	1.7%
8	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк	285.0	1.7%
9	Бүгд найрамдах Австри улс	211.5	1.3%
10	Кредит свисс банк	171.0	1.0%
11	Бүгд найрамдах Энэтхэг улс	149.7	0.9%
12	Бусад зээлдүүлэгч	631.2	3.8%
НИЙТ		16,494.1	

2.1.6 Засгийн газрын өрийн баталгаа

- Монгол Улсын Засгийн газар 2012 оноос хойш нийт 11 зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргасан бөгөөд Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 1,663.7 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,060.4 тэрбум төгрөгт хүрч буураад байна.
- Мөн Засгийн газар 2015 онд Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээл дээр гаргасан 500.0 сая ам.долларын үнэт цаасанд Засгийн газрын дотоод үнэт цаасыг барьцаалан өрийн баталгаа гаргасан бөгөөд энэхүү гадаад үнэт цаасны төлбөр 2020 оны 5 дугаар сард бүрэн төлөгдөж Засгийн газар баталгааны үүргээс чөлөөлөгдөөд байна.

5 Хүснэгт 20. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл

№	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Дүн	Баталгаа гаргасан огноо	Хүүгийн хувь	Хугацаа	Үлдэгдэл	
							тэрбум төгрөг	сая ам.доллар

1	МИАТ ХК	USA EXIM	77.5 сая \$	2013.12.24	2.52%	10 жил	52.3	18.3
2	Хөгжлийн банк	Японы зах зээл	30 тэрбум ¥	2014.01.06	1.52%	10 жил	827.4	290.4
3	Хөгжлийн банк	Хятадын хөгжлийн банк	162 сая \$	2014.09.03	6.00%	8 жил	153.9	54.0
4	Эрдэнэс Монгол	Азийн хөгжлийн банк	35 сая \$	2016.04.01	0.5+LIBOR	15 жил	26.9	9.4
Нийт							1,060.4	372.1

Засгийн газар 2016 оны 6 дугаар сараас хойш шинээр Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй бөгөөд цаашид Засгийн газрын өрийн баталгааны хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, гаргасан Засгийн газрын өрийн баталгаат зээллэгийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах бодлогыг баримтлан ажиллаж байна.

5.1.6 "Барих-шилжүүлэх" төрлийн концесс

Өрийн удирдлагын тухай хуулиар улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдох бөгөөд улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэн Засгийн газрын өрийн үлдэгдэлд бүртгэж байна. Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээний Засгийн газрын өрд бүртгэгдсэн дүн 2017 оны эцэст 768.2 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 850.2 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.

Үүнээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээний үлдэгдэл 2017-2020 онд нэмэгдсэн бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын үлдэгдэл буурсан байна. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын өрийн хэмжээ нэмэгдсэн нь улсын төсвөөс төлөгдөх концессын гэрээний дийлэнх нь 2015-2016 онд байгуулагдаж, төслүүдийн гүйцэтгэл 2017-2020 онуудад хийгдэж, төслийн хэрэгжилт үргэлжилж байгаатай холбоотой.

Хүснэгт 21.Концессын гэрээний үлдэгдэл

Барих-шилжүүлэх Концесс	Төслийн тоо	Гэрээний дүн (тэрбум ₮)	Үлдэгдэл (тэрбум ₮)
Улсын төсөв	10	1,286.1	849.5
Гүйцэтгэл 100%	8	990.2	710.4
Гүйцэтгэл 38-64%	2	295.9	139.1
Орон нутаг	6	4.9	0.7
Баянхонгор аймаг	1	3.7	0.2
Говь-Алтай аймаг	2	0.04	0.04
Завхан аймаг	1	0.5	0.1
Ховд аймаг	2	0.6	0.4
НИЙТ	16	1,291.0	850.2

Харин орон нутгийн төсвөөс төлөгдөх концессын гэрээнүүд 2012-2014 онд байгуулагдсан бөгөөд дийлэнх гэрээний эргэн төлөлт 2015-2017 онд төлөгдсөнөөр үлдэгдэл багассан байна.

"Барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээ нь Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг өсгөснөөр төсөвт дарамт учруулж байсан тул Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолоор барих-шилжүүлэх төрлийн


концессын гэрээг дахин байгуулахгүй байх, гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл, арга хэмжээг зогсоохыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Үндэсний хөгжлийн газарт даалгасан. Үүний дагуу Сангийн яамнаас улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй аливаа төсөл, арга хэмжээг концессын гэрээгээр хэрэгжүүлэхгүй байхад хяналт тавин ажиллаж байна.

2.2. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Засгийн газрын баталгаа нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна.

Засгийн газрын гаргасан баталгааны хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын евро бондын төлбөрийг баталгааны үүргийн дагуу Засгийн газар төлж барагдуулсан. Бусад Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн төлбөрийг Монгол Улсын Хөгжлийн банк, МИАТ ТӨХК, Худалдаа хөгжлийн банк, Эрдэнэс Монгол ХХК зэрэг зээл авсан байгууллагууд эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн гүйцэтгэж байна.

Зураг 43. Засгийн газрын баталгаатай зээлийн эргэн төлөлтийн хуваарь /сая ам.доллар/



Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн 92.6 хувийг Монгол Улсын Хөгжлийн банкны “Самурай” бонд, Хятадын хөгжлийн банкны зээлд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа эзэлж байгаа бол “МИАТ” ТӨХК-ны “Бойнг” агаарын хөлөг худалдан авсан зээлийн баталгаа 5.1 хувь, Эрдэнэс Монгол ТӨХК-ны Азийн хөгжлийн банкнаас авсан зээлийн баталгаа 2.3 хувийг тус тус эзэлж байна. Монгол Улсын Засгийн газар төсвийн сахилга батыг сайжруулах, болзошгүй өр төлбөрийг бууруулах бодлогыг баримталж 2016 оноос хойш Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй.

МИАТ ТӨХК-д гаргасан Засгийн газрын баталгаа.

1. Бойнг агаарын хөлөг худалдан авсан зээл: МИАТ ТӨХК нь 2013 оны 12 сарын 24-ний өдөр 121.4 сая ам.долларын 5, 7, 10 жилийн хугацаатай 3 дэд хэсгээс бүрдэх зээллэг хийсэн бөгөөд Засгийн газрын 2013 оны 319 дүгээр тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МИАТ ТӨХК нь зээлийн эх үүсвэрээр Боинг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авсан бөгөөд зээлийн үлдэгдэл 2020 оны эхний хагас жилийн байдлаар 65.7 тэрбум төгрөг байна. Үүнээс АНУ-ын Экспорт Санхүүжилтийн хувийн корпораци (ЭСХК) 77.4 сая ам.долларын зээлийн үлдэгдэл 22.4 сая ам.доллар буюу 63.3 тэрбум төгрөг, Ай Эн Жи Капиталаас авсан 23.9 сая ам.долларын зээлийн үлдэгдэл 0.9 сая ам.доллар буюу 2.4 тэрбум

төгрөг байна. Харин Ай Эн Жи банкнаас зээлсэн 5 жилийн хугацаатай 20.0 сая ам.долларын зээл бүрэн төлөгдөж дууссан. Ай Эн Жи Капиталын дэд зээлийн төлбөр 2020 онд төлөгдөж дуусах бөгөөд АНУ-ын ЭСХК-ийн зээлээс 2021 онд 8.2 сая ам.доллар буюу 24.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 0.4 сая ам.доллар буюу 1.2 тэрбум төгрөг хүүгийн төлбөр төлөгдөх хуваарьтай байна.

МУХБ-д гаргасан Засгийн газрын баталгаа.

2. “Самурай” үнэт цаас - МУХБ 2014 оны 01 сарын 06-ны өдөр Японы зах зээл дээр 30.0 тэрбум иенийн “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй арилжаалсан бөгөөд Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ нь “Самурай” үнэт цаасны эх үүсвэрийг “ТОСК” ТӨҮГ, Эрэл ХХК, “Хөтөл” ХХК зэрэг байгууллагуудын 5 төрлийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд ашигласан байдаг. МУХБ гэрээний дагуу “Самурай” үнэт цаасны үндсэн төлбөрийг 2023 онд төлөх бөгөөд 2021 онд 456.0 сая японы иен буюу 12.4 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөх хуваарьтай байна.

3. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл – МУХБ 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр БНХАУ-ын Хөгжлийн банкнаас 162.0 сая ам.долларын 8 жилийн хугацаатай, 6.0 хувийн хүүтэй, зээл авсан бөгөөд Засгийн газрын 2014 оны 116 дугаар тогтоолын дагуу Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ уг зээлийн эх үүсвэрийг Амгалан дулааны станц, Баянхонгор-Алтай чиглэлийн 128 км авто зам, Улаангом-Наранбулаг чиглэлийн 90 км авто зам зэрэг нийт 11 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан. Зээлийн үлдэгдэл 2020 оны эхний хагас жилийн байдлаар 67.5 сая ам.доллар буюу 190.6 тэрбум төгрөг байна. МУХБ зээлийн төлбөрийг 2022 онд төлж дуусах бөгөөд 2021 онд 27.0 сая ам.доллар буюу 79.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 2.9 сая ам.доллар буюу 8.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөх хуваарьтай байна.

3. “Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа.

Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл – “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын LIBOR+0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. “Эрдэнэс Монгол” ХХК уг зээлийн эх үүсвэрийг компанийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөлд ашиглаж байна. Зээлийн үлдэгдэл 2020 оны эхний хагас жилийн байдлаар 8.9 сая ам.доллар байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна. “Эрдэнэс Монгол” ХХК 2021 онд 0.16 сая ам.доллар буюу 0.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 0.22 сая ам.доллар буюу 0.7 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөх хуваарьтай.

БҮЛЭГ ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ҮЛДЭГДЛИЙН НИЙТ ДҮН, ЭНЭ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ДАРААГИЙН ЖИЛИЙН ХУГАЦААН ДАХЬ ТУХАЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ҮНЭЛГЭЭ

3.1. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНД ШИЛЖҮҮЛСЭН ЭРДЭС, БАЯЛГИЙН ОРЛОГО, САНГИЙН ЗАРЛАГА

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдсанаар Төсвийн тогтворжуулалтын сан (ТТС)-г байгуулсан. Энэхүү сан нь эдийн засгийн мөчлөг болон эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл, экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, тогтворжуулах зорилготой бөгөөд төсвийн орлогын тасалдал, алдагдлыг нөхөх зориулалтаар үнэ тогтвортой буюу өсөлттэй үед хуримтлуулдаг.

ТТС-д 2011 оны 2 дугаар сараас хуримтлал бий болж эхэлсэн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар 89.7 тэрбум төгрөгийн хуримтлалтай байсан бол 2020 онд сангийн хуримтлалыг хуулийн дагуу төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар улсын төсөвт шилжүүлсэн.

Хүснэгт 22. ТТС-ийн орлого, зарлага, хуримтлал, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020 УГ	2021 бат
ТТС-ийн орлого	0	325.7	206.9	94.6	66.2	156.0
АМНАТ-өөс, ЗГ-ын нөөц сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл	0.3	331.0	207.3	100.2	66.2	156.0
Хүүгийн орлого	10.1	14.6	-	-	-	-
ТТС-ийн зарлага (Улсын төсөвт шилжүүлэг)		572.1	-	322.0	138.8	156.0
ТТС-ийн хуримтлал	332.4	104.2	311.5	89.7	-	-

Сангийн орлого нь нэгдсэн төсвийн орлогын гурваас дээш хувийг бүрдүүлэгч гол нэр төрлийн эрдэс баялгийн зах зээл дээрх үнээс хамааран хэлбэлзэж байдаг ба 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр эрдэс баялгийн орлогоос санд 66.2 тэрбум төгрөг төвлөрсөн бол 2021 онд 156.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож байна.

Хуульд ТТС-ийн хөрөнгөөс тодорхой нөхцөл байдлын улмаас үүссэн төсвийн орлогын тасалдал болон тухайн жилийн төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар улсын төсөвт шилжүүлж болохоор заасан ба сангийн хуримтлалаас 2017 онд 572.1 тэрбум төгрөг, 2019 онд 322.0 тэрбум төгрөг, 2020 онд 138.8 тэрбум төгрөгийг улсын төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар шилжүүлсэн бол 2021 онд 156.0 тэрбум төгрөгийг шилжүүлэхээр тооцож байна.

3.2. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ХУРИМТЛАЛЫН ТАЛААРХ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд ТТС-ийн хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас доошгүй байх ба уг нөхцөлийг 2020 оны төсвийн жилээс өмнө хангахаар заасан байсан бөгөөд төсвийн алдагдлыг үе шаттай бууруулах, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бууруулах зорилтын хүрээнд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулан дээрх шаардлагыг хүчингүй болгосон.

БҮЛЭГ ДӨРӨВ. СОНГУУЛИЙН ЖИЛД ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ ДАРААГИЙН ЖИЛҮҮДИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ҮЗҮҮЛЭЛТ

4.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНД ТӨСВӨӨС ГАРГАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

УИХ-ын 2020 оны сонгуулийн жил, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн жилд Засгийн газраас дараагийн төсвийн жилүүдийн санхүү, төсвийн төлөв байдалд нөлөөлөхөөр шийдвэр гаргаагүй байна.

Өнгөрсөн 2020 онд Төсвийн тогтворжуулалтын санд 66.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд 2021 онд 156.0 тэрбум төгрөг, 2022 онд 61.5 тэрбум төгрөг, 2023 онд 69.5 тэрбум төгрөгийг тус санд төвлөрүүлэхээр тооцсон болно.

Коронавируст цар тахлын улмаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд тулгараад байгаа хүндрэлийг бууруулах, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдөр УИХ-аас Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай хуулийг баталсан. Энэ хуулийн хүрээнд 356,233 татвар төлөгчийг 110.0 орчим тэрбум төгрөг /2020 онд 49.0 орчим тэрбум төгрөг, 2021 онд 60 орчим тэрбум төгрөг/-ийн татварын алданги, торгуулиас чөлөөлөхөөр байна.

Түүнчлэн, түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжүүдэд бууруулсан хэмжээгээр татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ; хүнсний хангамжийг тогтворжуулах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос болон өвс, мал, амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгасан болно. Мөн цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, дотоодын эм, эмийн бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулах зорилгоор Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх юм. Эдгээр арга хэмжээнүүдийн хүрээнд 2021 онд 46.0 орчим тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлнэ.

БҮЛЭГ ТАВ. ИРЭХ ДӨРВӨН ЖИЛИЙН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ

5.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ

Дотоодын нийт бүтээгдэхүүн. КОВИД-19 вирусийн дэгдэлтийн нөлөөг бууруулах бодлогууд болох иргэд болон ААН-ийг зарим татвараас чөлөөлөх, хойшлуулах, ажлын байрыг хадгалах, малчдын орлогыг дэмжих зэрэг бодлогуудыг үргэлжлүүлэхтэй холбоотойгоор 2021 онд эдийн засаг сэргэх төлөвтэй байна. Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарын үйлдвэрлэл сэргэж, эдийн засгийн өсөлтийг дагасан автобензин, дизель түлшний импорт нэмэгдэх төлөвтэй байна.

Ирэх жилүүдэд “Алсын хараа-2050” болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эдийн засгийн суурь орчныг шинэчлэх, макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх бодлогуудыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдахаар байна. Газрын тосны үйлдвэр болон төмөр замыг барьж байгуулах, цэвэрлэх байгууламж барих, Оюутолгойн далд уурхайн төслүүд үргэлжилж, барилга, угсралтын ажил идэвхжиж, Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2021-2024 онд урт хугацааны өсөлтийн түвшинд буюу дунджаар 6.0 орчим хувиар өсөхөөр байна.

Гадаад худалдаа. Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт дунд хугацаанд нэмэгдэж, 2021-2024 онд гадаад худалдааны тэнцэл дунджаар 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Үүнд Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл болон чулуун нүүрсний экспорт нэмэгдэхээр байгаа нь голлох нөлөөг үзүүлэхээр байна.

Инфляц. Засгийн газраас иргэд болон ААН-ийг дэмжих зорилгоор 2020 онд гаргасан цахилгаан, дулаан, хог, хатуу түлшний үнийг чөлөөлөх шийдвэрийн үйлчлэл 2021 онд дуусахаар байгаа ч инфляцын түвшин 2021 онд зорилтот түвшин буюу 7 орчим хувьд, дунд хугацаанд буюу 2022-2024 онд 6 орчим хувьд байхаар байна.

Хөдөлмөр эрхлэлт. Ирэх 4 жилд Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн ам 2.3 саяд хүрч, ажиллах хүчин 1.5 сая хүн болж, ажиллах хүчний оролцооны түвшин 62.3 хувьд хүрч тус тус өсөхөөр байна. Мөн ирэх онуудад хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд, эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор ажилгүйдлийн түвшин дунджаар 0.7 нэгжээр буурах хандлагатай байна.

Хүснэгт 23. Монгол Улсын макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, 2021-2024

	2021	2022	2023	2024
ДНБ-ий бодит өсөлт (хувь)	7.2	4.4	6.5	6.0
Хөдөө аж ахуйн салбарын өсөлт	4.7	5.6	1.4	4.0
Үйлдвэрлэлийн салбарын өсөлт	8.7	1.6	10.0	9.0
Үйлчилгээний салбарын өсөлт	5.6	5.4	5.3	5.0
Экспортын хэмжээ (сая ам.доллар)	7,892.8	7,341.7	7,892.8	8,187.0
Импортын хэмжээ (сая ам.доллар)	6,177.5	6,622.8	7,016.4	7,220.0
Гадаад худалдааны тэнцэл (сая ам.доллар)	1,715.3	718.9	876.5	967.0
Хэрэглээний үнийн өсөлт (оны эцэст)	7.0	6.0	6.0	6.0
Ажилгүйдлийн түвшин, хувь	8.7	7.4	6.7	6.0
Хүн амын дундаж тоо, мян хүн	3,409.3	3,477.5	3,547.0	3,618.0

5.2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ

Дунд хугацааны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахдаа төсвийн орлогын төлөвлөлтийг сайжруулах, өнөөгийн мөрдөж буй хууль, эрх зүйн орчин, Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан тогтоол шийдвэрүүдийн хүрээнд эдийн засгийн өсөлт, гадаад, дотоод, орчны нөхцөл байдалд үндэслэн, дотоодод хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд, цаашид хэрэгжих томоохон төсөл хөтөлбөр, арга хэмжээний нөлөөллийг харгалзан үзлээ.

Монгол Улсын тэнцвэржүүлсэн нийт орлого 2021 онд 11,797.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 27.9% хувьд хүрэхээр байгаа бөгөөд 2023 онд 12,002.5 тэрбум төгрөг хүрч өсөхөөр байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ирэх 4 жилд дунджаар 3 хувиар өсөхөөр байгаа бөгөөд орлогын өсөлтөд ДНБ-ий бодит өсөлт, эрдэст бүтээгдэхүүний экспортын хэмжээ, үнэ зэрэг эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлж байна.

5.3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨСӨӨЛӨЛ

Суурь үзүүлэлт. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасныг үндэслэж УИХ-аас 2021 оны жилийн төсвийг батлахдаа нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 13,951.6 тэрбум төгрөг байхаар тогтоосон. Энэ нь 2020 оны урьдчилсан гүйцэтгэлтэй харьцуулбал 9.2 хувийн бууралттай байна.

Түүнчлэн УИХ-аас баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2021 онд 13,951.6 тэрбум төгрөг (бууралт 1.5 хувь), 2022 онд 13,068.7 төгрөг (бууралт 1.9 хувь) байхаар төсөөлж хуульчлан тогтоосон байна.

Хэрэгцээ. Нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж болон төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулахад чиглэсэн шинэчлэлийг эхлүүлнэ. Иргэндээ ээлтэй эрүүл мэндийн шинэчлэлийг хэрэгжүүлж, чанарыг дээдэлсэн боловсролын шинэчлэлийг эхлүүлнэ. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэлтэй үед нийт иргэдийн орлогыг хамгаалах, нийгмийн туслалцаа дэмжлэг зайлшгүй шаардлагатай эмзэг бүлгийн иргэдийн халамжийг нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа Засгийн газрын арга хэмжээг 2021 онд хэсэгчлэн үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд ирэх 2021 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн чиглэлээр:

Эрүүл мэндийн салбарт иргэнээ дагасан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлнэ:

Иргэд өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас өвчин, эмгэгийн төрлөөс үл хамааран шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, шуурхай авдаг болох зорилгоор эрүүл мэндийн салбарт хуваарилах санхүүжилтийг нэг худалдан авагчийн зарчмаар буюу эрүүл мэндийн даатгалын байгууллага улсын төсвөөс олгож байгаа санхүүжилтийг хуваарилдаг тогтолцоонд шилжинэ.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоонд шинэчлэл хийснээр 1/ бүх шатны эмнэлэг, эмийн сан, иргэн-даатгуулагчийг холбосон цахим систем бий болгож санхүүжилтийг оновчтой үр ашигтай хуваарилна; 2/ иргэд ЭМД-аараа улсын болон хувийн эмнэлгийг сонгож үйлчлүүлдэг болно; 3/ эмнэлэг гүйцэтгэлээрээ санхүүжилт авч, эмч, ажиллагчдын цалинг ажлын үр дүнтэй уялдуулж нэмэгдүүлэх боломж бүрдэнэ; 4/ хөнгөлөлттэй эмийг бүх шатны

эмнэлгийн эмч бичиж бүх эмийн сан олгодог болно; 5/ стандартын шаардлага хангаагүй, хуурамч эмийг зах зээлээс шахаж, эмийн чанар сайжирч, үнэ буурна.

2/. Боловсролын салбарын шинэчлэлийн чиглэлээр:

- Боловсролын чанарыг сайжруулахад чиглэсэн үнэлгээний тогтолцоог бий болгоно. Суралцагчийн сурлагын чанарыг үнэлэх цахим систем бий болгож, улсын хэмжээнд сургуулиудын чанарын үзүүлэлтийн нэгдсэн жагсаалт гаргадаг болно. Багшийг суралцагчийн сурлагын амжилт, ахиц дэвшлээр үнэлэхэд өндөр ач холбогдол өгдөг болно;
- Багшийг хөгжүүлэх цахим хөтөлбөр хэрэгжүүлж багшийн цалин хөлсийг оновчтой төлөвлөж хуваарилна. Багшийн заах арга зүйг сайжруулах, мэргэжил дээшлүүлэх цахим сургалтын орчныг бий болгож багшийг өөрөө өөрийгөө хөгжүүлэх, ур чадвараа нэмэгдүүлэх боломжоор хангана. Багшийн цалин хөлсний шударга тогтолцоог бий болгож, суралцагчийн чанарт ахиц гарсан тохиолдолд урамшуулал, нэмэгдлүүдийг бүрэн олгодог болно. Багшийн цалин хөлсийг төрийн албаны хүний нөөцийн болон цалингийн нэгдсэн системээр дамжуулан олгодог болно;
- Дээд боловсролын тэтгэлэгт хамрагдах их, дээд сургуулиудыг эрэмбэлнэ. Цаашид зөвхөн ирээдүйгээ харсан тэргүүлэх, өнөөдөр нэн шаардлагатай байгаа хэрэгцээт мэргэжлээр суралцаж байгаа суралцагсдад сургалтын зээл болон тэтгэлэг олгодог болно;
- Ерөнхий боловсролын сургуулиудын байршлын зураглал (school mapping)-г улсын хэмжээнд хийнэ. 16 Газарзүйн мэдээллийн GIS системд суурилсан сургуулийн зураглалыг тухайн орон нутгийн хүн амын нягтшил, сургуулийн насны хүүхдийн тоо, газарзүйн онцлог, дэд бүтцийн хөгжил, төвөөс алслагдсан байдал, сургуулийн болон дотуур байрны хүчин чадал, сургалтын орчин нөхцөл зэрэг хүчин зүйлсийг харгалзан хийж ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, байршил, хэв шинжийн оновчтой хувилбарыг тогтоож, зохих өөрчлөлт хийнэ. Ингэснээр сургуулиудын бүлэг дүүргэлт нэмэгдэж, багшийн хүрэлцээ, сургалтын орчин нөхцөл, суралцагчийн сурлагын чанарт ахиц гарна;
- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хүртээмжийг сайжруулна. Төрөөс олгох санхүүжилтийг бууруулахгүйгээр орон нутгийн онцлог, хүүхдийн тоо, хүчин чадалдаа тохируулан хоолны тарифыг нэмэгдүүлэх асуудлыг бие даан шийдвэрлэх эрхийг хүүхдийн цэцэрлэг, эцэг эхийн зөвлөлд олгоно;
- Боловсролын санхүүжилтийн тогтолцоог үр дүнд суурилан тооцдог болох;
- Багш, ажилчдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, нэмэгдүүлэх;
- Боловсролын зээлийн сагийн санхүүжилтийг оновчтой болгох, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих эрх зүйн орчныг шинэчлэх;
- Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийж, давхцалыг арилгах эрх зүйн болон төсөв санхүүгийн бодлогыг шинэчлэх, боловсронгуй болгох;
- “Багш-орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлүүлэх”;
- Багш, сурагч бүрийг зөөврийн компьютер, ухаалаг утас, планшетаар хангаж, цахимаар ажиллаж, сурах нөхцөл, бололцоог бүрэлдүүлэх.

3/. Иргэдийн орлогын баталгааг сайжруулах чиглэлээр:

- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид ажиллаж байгаа даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулна. Одоо 20-22 хувь байгаа НДШ-ээс ажилгүйдэл, тэтгэмж болон ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 3-5 пунктээр бууруулж 17 хувьд хүргэнэ. Ингэснээр коронавируст цар тахал (КОВИД-19)-ын үед бизнес эрхлэгчдэд ашиг орлого, ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх боломж олгоно.

- Иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн нийгмийн халамжийн зарим арга хэмжээг 2021 оны эхний хагас жил дуустал нэмэгдүүлсэн дүнгээр үргэлжлүүлэн олгоно. КОВИД-19 цар тахлын эрсдэлийн эсрэг Засгийн газраас хэрэгжүүлэх багц арга хэмжээний хүрээнд 2020 оныг дуустал нэмэгдүүлсэн хэмжээгээр олгож байгаа Хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн тэтгэмжийг 2021 оны эхний хагасыг дуустал хугацаанд үргэлжлүүлэн олгоно.

4/. Цахим, ил тод, үр ашигтай төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж төсвийн урсгал зардлын өсөлтийг бууруулна:

- Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг үе шаттайгаар, тусгай зөвшөөрөл олгох процессыг бүрэн цахимжуулна. Түүнчлэн төрийн байгууллагуудын сургалт семинар, гадаад дотоод томилолт, хяналт шалгалтын чиг үүргийг тэргүүн ээлжид цахимаар хэрэгжүүлж холбогдох зардлыг бууруулж, цаг хугацааг хэмнэнэ.
- Төрийн албаны хүний нөөц ба цалин хөлсний системд бүрэн шилжинэ. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй төрийн албан хаагчийн мэдээлэлд суурилсан Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ээс улсын хэмжээнд нэвтрүүлнэ. Салбаруудын орон тоонд хяналт тавьж, давхардсан болон илүүдэл орон тоог илрүүлэх замаар орон тоог дахин хуваарилах, бууруулах зэргээр цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгож зардлын өсөлтийг тогтворжуулна.
- Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим системээр гүйцэтгэнэ. Нийгмийн халамжийн 73 төрлийн үйлчилгээг авахад бүрдүүлэх шаардлагатай 36 төрлийн бичиг баримтыг төрийн үйлчилгээний цахим системүүдээс автоматаар шалгаж, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг иргэдийн дансанд шуурхай шилжүүлдэг тогтолцоонд ирэх оноос бүрэн шилжинэ.

Үр ашигтай байх: Санхүүжилтийн механизмыг нь өөрчлөх замаар эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт тогтолцооны шинэчлэл хийж төсвийг нь дахин хуваарилж, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

Ил тод, шуурхай байх: Бүх салбарын тусгай зөвшөөрөл олгох процесс болон төрийн үйлчилгээг цахимжуулж, мэдээллийг ил тод, ойлгомжтой болгоно. Иргэд хүргэх төрийн үйлчилгээг шуурхай, хүнд сурталгүй хүргэнэ.

Хэмнэлттэй байх: Ухаалаг, хэмнэлттэй техник технологийн дэвшлийг ашиглан бүх шатны төсвийн байгууллагын захиргааны удирдлага, үйлчилгээ болон хөрөнгийн ашиглалтын зардлыг бууруулна.

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахад баримталсан БОДЛОГО:

- Төрийн албан хаагчийн цалин хөлс, ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийг 2020 оны түвшинд хадгална;
- Төрийн албан хаагчийн орон тоог цахим системээр хянан баталгаажуулж, давхардсан болон илүүдэл орон тоо, цалин хөлсний зардлын өсөлтийг дунд хугацаанд хязгаарлана.
- Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын эрсдэлтэй нүүр тулж ажиллаж байгаа төрийн байгууллагаас бусад төсөвт байгууллагын тэвчиж болох урсгал зардлыг бууруулна.

Тусгай зөвшөөрөл олгох процесс болон иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулж, эдгээртэй холбоотой орон тоо, урсгал зардал, цаг хугацааг хэмнэнэ. – Төрийн албан хаагчийн

гадаад, дотоод томилолт, хурал зөвлөгөөн, сургалт семинарын үйл ажиллагааг цахимжуулж холбогдох зардлыг хэмнэнэ.

Хэрэгцээ. Хүн амын өсөлт, үнэ ханшны өөрчлөлт, түүнчлэн Улсын Их Хурал, Засгийн газрын 2020 оноос өмнө гаргасан шийдвэрийн төсвийн зарлагад нөлөөлөх үр дагавар бүхий шийдвэр, арга хэмжээнүүд нь төсвийн урсгал зарлагыг 2022 онд 663.4 тэрбум төгрөг, 2023 онд 716.5 тэрбум төгрөг, 2024 онд 810.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх урьдчилсан тооцоолол байна.

Хүснэгт 24. Зардлын хэрэгцээний төсөөлөл ангилж харуулсан байдал /тэрбум төгрөг/

№	Арга хэмжээ зардал	2021 оны суурьтай харьцуулахад нэмэгдэх зардал		
		2022 онд	2023 онд	2024 онд
	НИЙТ ЗАРДАЛ	663.4	716.5	810.8
I.	2020 оноос өмнө батлагдсан хууль тогтоомжийн дагуу хэрэгжих арга хэмжээнүүд	253.8	274.1	333.0
II.	Статистик, хүн амзүйн өөрчлөлт болон хөрөнгө оруулалтаас шалтгаалан нэмэгдэх зардал, арга хэмжээ:	409.7	442.5	477.8

ЗУРГАА. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ НЬ УЛСЫН ИХ ХУРЛААР БАТЛАГДСАН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, ЭСХҮЛ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙГАА ТАЛААРХ ТАЙЛБАР

6.1. ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ НЬ ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БУЙ ТАЛААР

Ирэх жилүүдийн төсвийн төсөөллийн хувьд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд дараах байдлаар хангагдахаар байна.

- Төсвийн орлогын тусгай шаардлага:* 2021-2023 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэн, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.
- Төсвийн тэнцлийн тусгай шаардлага:* 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай” хуулийн дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дэх заалтын мөрдөх хугацааг нэг жилээр хойшлуулсан бөгөөд ирэх жилүүдийн төсвийн төсөөллөөр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тэнцлийн тусгай шаардлагыг хангахаар байна.

Хүснэгт 25. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл /ДНБ-д эзлэх хувь/

	2021	2022	2023
1 Хуулиар тогтоосон хязгаар	-5.1%	-3.6%	-2.8%
2 Төсөөлөл	-5.1%	-3.6%	-2.8%
	Хангасан	Хангасан	Хангасан

- Төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлага:* Нэгдсэн төсвийн нийт зарлага 2021 онд 4.3 хувиар буурах, 2022 онд 6.3 хувиар буурах, 2023 онд 2.6 хувиар өсөхөөр төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасан төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 26. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл /хувиар/

№	Өсөлт	2021	2022	2023
1	Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	8.5%	10.9%	9.0%
2	Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	17.4%	17.9%	14.4%
3	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь, төсөөлөл	-4.3%	-6.3%	2.6%
		Хангасан	Хангасан	Хангасан

6.2. ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛТЭЙ НИЙЦЭЖ БУЙ ТАЛААР

Ирэх жилүүдийн төсвийн төсөөллийг 2020 оны 8 дугаар сарын 28-ний өдөр УИХ-аар батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсөөллийн тухай хуультай нийцүүлэн боловсрууллаа. 2022-2023 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тогтоосон төсвийн төсөөлөлтэй нийцтэй буюу хуульд заасан хэмжээнд байхаар байна.

САНГИЙН ЯАМ